Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 1.1.1. | Эрүүл мэндийн байгууллагуудын иргэдэд үйлчлэх орчныг сайжруулж эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг нэмэгдүүлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ | 126,0 сая | Их засвар хийсэн ЭМТ-ийн тоо Шинээр барьж эхэлсэн Ашиглалтад орсон ЭМТ-ийн тоо Арга хэмжээний тоо | - - 1 2 | 2 1 1 3 | 2024 онд Эрүүл мэндийн салбарт хийгдэх барилга байгууламж, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг төлөвлөлтөд тусган Онгон сумын ЭМТ-ийн барилгын их засвар, Халзан сумын амбулаторийн барилгын их засвар, Түмэнцогт сумын ЭМТ-ийн барилгыг шинээр барих ажлыг орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж байна. Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл болон тендер шалгаруулах ажиллагаа, багаж тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөх ажиллагаанд хяналт тавьж ажилласан. Эрүүл мэндийн яам, Дэлхий банкны 1,4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “G14-3 иж бүрдэл Компьютер томографын аппаратын засвар үйлчилгээ суурилуулах ажил хийгдэж дууссан. | 100% |
| 1.1.1.1 | Сумдад Эх хүүхдийн баг ажиллуулах | 5,0 | Ажилласан сумдын тоо | 3 | Эхний хагас жилд: 5 Жилийн | Ажиллах ажлын хэсгийг хуралдаж, сумдаар явах маршрут болон ажиллах хүний нөөцийг бэлтгэсэн. Эх хүүхдийн баг сумдад ажиллах санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эцэст: 5 | Хүрсэн түвшин: - | |
| 1.1.1.2 | Эмч, эмнэлгийн ажилтан, анагаахын салбарын оюутнуудыг дэмжих, урамшуулал олгох | 20,0 | Урамшуулалд хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | 5 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 5 | Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын идэвх санаачилгын дэмжих урамшууллын багцыг хэрэгжүүлж болзол хангасан эмч, мэргэжилтэнд урамшуулал олгох аймгийн Засаг даргын шагналын болзлыг хангасан эмч, мэргэжилтэн , ажилтны шалгаруулалтыг журмын дагуу явуулж шагналыг олгосон. Уг шагналд засаг даргын үйл ажиллагаа хэрэгжүүлэх зардлаас 20 сая төгрөгийг зарцуулсан байна.<br>Хүрсэн түвшин: 5 | 100% |
| 1.1.1.3 | Эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулж шагналыг олгох | 1,0 | ЭМДБ-ын тоо | 28 | Эхний хагас жилд: 30 Жилийн эцэст: - | Аймгийн Засаг даргын 2018 оны А/61 дүгээр захирамжаар байгуулагдсан Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, эрүүл ажлын байр шалгаруулах орон нутгийн комисс нь 2023 онд шалгаруулалтад оролцсон 11 байгууллагын тайлантай танилцаж, шаардлага хангасан Баруун-Урт сумын 1 дүгээр цэцэрлэг 2 дугаар зэрэг, Боловсрол өргөө дотуур байр 3 дугаар зэргийн гэрчилгээ олгосон, ба материал ирүүлсэн байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн. Сүхбаатар аймгийн хэмжээнд 1-р зэрэглэлийн 3, 2-р зэрэглэлийн 9, 3-р зэрэглэлийн 18 нийт 30 байгууллага Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болсон байна.<br>Хүрсэн түвшин: 30 байгууллага | 100% |
| 1.1.1.4 | Эрүүл мэндийн салбарт хийгдэх барилгын их засвар, шинээр баригдах барилга, тоног төхөөрмжийн тендерийн | - | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 3 | 2024 онд Эрүүл мэндийн салбарт хийгдэх барилга байгууламж, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг төлөвлөлтөд тусган Онгон сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар, Халзан сумын амбулаторийн барилгын их засвар, Түмэнцогт сумын ЭМТ-ийн барилгыг шинээр барих ажлыг орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж байна. Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тодорхойлолт бэлтгэх болон ажлын явцад холбогдох ажилтан, байгууллагын хамт хяналт тавих | | | | | тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл болон тендер шалгаруулах ажиллагаа, багаж тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөх ажиллагаанд хяналт тавьж ажилласан. Эрүүл мэндийн яам, Дэлхий банкны 1,4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр "G14-3 иж бүрдэл Компьютер томографын аппаратын засвар үйлчилгээ суурилуулах ажил хийгдэж дууссан.<br>Хүрсэн түвшин: ЭМТөвийн их засвар 3 Тоног төхөөрөмжийн суурилалт 1 Хяналт тавьж ажилласан 1 | |
| 1.1.1.5 | Эрүүл Сүхбаатарчууд төслийг хэрэгжүүлэх урвалж оношлуурын тендерийн тодорхойлолтыг гаргаж зарлуулан хэрэгжилтэд хяналт тавих | 62,0 | Тендерийн тодорхойлолт гаргасан эсэх | 1 | Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: - | Аймгийн засаг даргын 2022 оны А/290 дүгээр захирамжийн дагуу ЭМД-гүй иргэдийг 5 төрлийн шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Эрүүл Сүхбаатарчууд төслийн хүрээнд урвалж оношлуурын тендэрийг 2022, 2023 онуудад гаргасан. 2024 оны 11 сарын байдлаар 5 төрлийн оношлуураар эрүүл мэндийн даатгалгүй хамрагдвал зохих 10130 иргэнээс 5814/57,3% (сахар-1050, холестерин- 657, ХДХВ/ДОХ-1082, Тэмбүү-1082, хеликобактер-1228) иргэнийг шинжилгээнд хамруулсан. Чихрийн шижингийн сэжигтэй тохиолдол-31, хеликобактерын сэжигтэй тохиолдол-167 илэрч баталгаажуулах шинжилгээнд илгээж, эмчийн хяналтад авсан. ХДХВ/ДОХ-ын шинэ халдвар илрээгүй байна. Халзан, Баяндэлгэр сумд эрүүл мэндийн даатгалгүй иргэдээ 100% шинжилгээнд хамруулсан байна<br>Хүрсэн түвшин: 1 | 100% |
| 1.1.1.6 | Олон нийтэд түшиглэсэн нялхас, бага насны хүүхдийн | - | Сургалтад хамрагдсан эмч мэргэжилтний тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 60 | Зудын нөхцөл байдалд НҮБ-ын хүүхдийн сангийн санхүүжилттэйгээр аймгийн хэмжээ нь дэх 100-400 малтай малчин өрхийн 5 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхийг бичил тэжээлийн дутлаас сэргийлэх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хооллолтын зөвлөгөө өгөх эрүүл мэндийн ажилтан бэлтгэх сургалт зохион байгуулах | | | | | зорилгоор 0-23 сартай хүүхдийн эхийн сүүгээр хооллолт, нэмэгдэл хооллолтын талаар мэдлэг олгох, зөвлөгөө өгөх, хооллолтын бэрхшээлийг шийдвэрлэх, зөвшилцөлд хүрэх, хоол тэжээлийн цочмог дутал (ХТЦД)-тай хүүхдийг эрт илрүүлэх, эмчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх, эмчилгээг гүйцэд, үр дүнтэй хийх боломжийг бүрдүүлэх, сэргийлэх зэрэг нэн чухал асуудлыг багтаасан "Зудтай орон нутгийн ЭМБ-ын ажилтнуудад "Нялхас, бага насны хүүхдийн хооллолтыг гамшгийн үеийн арга хэмжээтэй уялдуулах нь" сургалтад 33 эмч, өрх, сумдын эрүүл мэндийн төвийн хүүхдийн эмч, багийн бага эмч нар хамрагдлаа. Сургалтыг үндэсний сургагч багш НЭМҮТ-ийн ХСХАБА-ны ЭШТА, АУ-ны доктор заасан.<br>Хүрсэн түвшин: 60 эмч сургалтад хамрагдсан. | |
| 1.2. | Боловсролын байгууллагын сургалтын орчинг сайжруулна. | 20680,0 | Шинээр болон засвар хийн Ашиглалтад оруулах сургууль, цэцэрлэг , дотуур байрын тоо | ЕБС -4<br>Цэц-1<br>дотуур байр-0 | ЕБС-2<br>Цэц-2<br>Дотуур байр -2 | Эрдэнэт ТӨҮГ-ын хөрөнгөөр 2023-2024 оны 2,3-р ээлжийн төсөлд 10 сумын 21 байгууламжаас цэцэрлэг-7, сургууль-6, дотуур байр-8 хамрагдахаас ашиглалтад цэцэрлэг-4, сургууль -4, дотуур байр - 5, нийт 13 байгууламж ашиглалтад оруулсан. Үлдсэн байгууламж 12 -р сард ашиглалтад оруулах улсын комисс ажиллана. Баруун-Урт суманд Улсын төсвийн хөрөнгөөр баригдсан 960 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулж орон нутгийн төсөвт тусган батлагдсан 150,0 сая, сумын хөгжлийн 151,0 сая төгрөгийн хөрөнгөөр тоног төхөөрөмжөөр хангасан. Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуульд 8,4 сая төгрөгийн хөрөнгөөр камер, Түвшинширээ сумын дотуур байранд 3,0 сая төгрөгөөр зөөлөн эд, Баруун-Урт сумын 2-р цэцэрлэгийн гадна тоглоомын талбайн тоглоом 6,0 сая, МБС ын 8,0 сая, төгрөгийн НҮБ-ийн Хүүхдийн сангийн дэмжлэгээр Халзан сумын хүүхдийн цэцэрлэгт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ном тоглоомын багцыг шийдвэрлэж өгсөн. ОХУ , Улаанбаатар РЦНК байгууллагатай хамтран зүүн бүсийн хими, математик, орос хэлний олимпиадыг зохион байгуулан, Баруун-урт сумын 3-р сургуульд орос хэлний кабинетын тохижуулахаар шийдвэрлэсэн. Улсын төсвийн 1,898,878.448 хөрөнгөөр Наран сумын 100 хүүхдийн цэцэрлэгийг ашиглалтад оруулж, стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн барилгын тоог нэмэгдүүлж, 50% д хүргэсэн. НҮБ-ийн Хүүхдийн сангийн дэмжлэгээр Халзан сумын хүүхдийн цэцэрлэгт ном тоглоомын багцыг шийдвэрлэж, Дарьганга , Онгон сумдын гэр цэцэрлэгийг 3,0 сая төгрөгийн чип багцаар хангаж , зуухгүй гэр цэцэрлэгийн тоог 2-оор нэмэгдүүлж 19 гэр цэцэрлэгт чип багцыг ашиглаж, хүүхдийг галд түлэгдэх эрсдэл, багш ажилчдыг тоос шороогүй, цэвэр цэмцгэр тав тухтай орчин нөхцлөөр ханган ажиллаж байна. Наран сум 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг "Хөх хайрхан трейд" ХХК гүйцэтгэж, Голомт Өргөө ХХК зохиож, 30х12 харьцаатай өрөгт бүтээцтэй, зоорьгүй 2 давхар, төвлөрсөн дулаанд холбогдсон бохир усны систем бие даасан төвийн цахилгаан, интернет сүлжээнд холбогдсон барилгын ашиглалтад оруулсан. | |
| 1.2.1 | Боловсролын байгууллагын сургалтын орчин нөхцлийг сайжруулах | 150,0 | Техник тоног төхөөрөмжөөр хангах ХАА зохион байгуулсан тоо | 0 | Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: - | Эрдэнэт ТӨҮГ-ын хөрөнгөөр 2023-2024 оны 2,3-р ээлжийн төсөлд 10 сумын 21 байгууламжаас цэцэрлэг-7, сургууль-6, дотуур байр-8 хамрагдахаас ашиглалтад цэцэрлэг-4, сургууль -4, дотуур байр - 5, нийт 13 байгууламж ашиглалтад оруулсан. Үлдсэн байгууламж 12 -р сард ашиглалтад оруулах улсын комисс ажиллана. Баруун-Урт суманд Улсын төсвийн хөрөнгөөр баригдсан 960 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулж орон нутгийн төсөвт тусган батлагдсан 150,0 сая, сумын хөгжлийн 151,0 сая төгрөгийн хөрөнгөөр тоног | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төхөөрөмжөөр хангасан. Дарьганга сумын Ерөнхий боловсролын сургуульд 8,4 сая төгрөгийн хөрөнгөөр камер, Түвшинширээ сумын дотуур байранд 3,0 сая төгрөгөөр зөөлөн эд, Баруун-Урт сумын 2-р цэцэрлэгийн гадна тоглоомын талбайн тоглоом 6,0 сая, МБС ын 8,0 сая, төгрөгийн НҮБ-ийн Хүүхдийн сангийн дэмжлэгээр Халзан сумын хүүхдийн цэцэрлэгт ном тоглоомын багцыг шийдвэрлэж өгсөн. ОХУ , Улаанбаатар РЦНК байгууллагатай хамтран зүүн бүсийн хими, математик, орос хэлний олимпиадыг зохион байгуулан, Баруун-урт сумын 3-р сургуульд орос хэлний кабинетын тохижуулахаар шийдвэрлэсэн. Улсын төсвийн 1,898,878.448 хөрөнгөөр Наран сумын 100 хүүхдийн цэцэрлэгийг ашиглалтад оруулж, стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн барилгын тоог нэмэгдүүлж, 50% д хүргэсэн. НҮБ-ийн Хүүхдийн сангийн дэмжлэгээр Халзан сумын хүүхдийн цэцэрлэгт ном тоглоомын багцыг шийдвэрлэж, Дарьганга , Онгон сумдын гэр цэцэрлэгийг 3,0 сая төгрөгийн чип багцаар хангаж , зуухгүй гэр цэцэрлэгийн тоог 2-оор нэмэгдүүлж 19 гэр цэцэрлэгт чип багцыг ашиглаж, хүүхдийг галд түлэгдэх эрсдэл, багш ажилчдыг тоос шороогүй, цэвэр цэмцгэр тав тухтай орчин нөхцлөөр хангаж ажиллаж байна. Наран сум 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг "Хөх хайрхан трейд" ХХК гүйцэтгэж, Голомт Өргөө ХХК зохиож, 30x12 харьцаатай өрөгт бүтээцтэй, зоорьгүй 2 давхар, төвлөрсөн дулаанд холбогдсон бохир усны систем бие даасан төвийн цахилгаан, интернет сүлжээнд холбогдсон барилгын ашиглалтад оруулсан.<br>Хүрсэн түвшин: 6 | |
| 1.2.2 | Шаардлагатай мэргэжлээр | 10 | Зөвлөх, ментор багшийн тоо | 10 | Эхний хагас | 2024 онд Боловсролын үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэх хүрээнд байгалийн ухааны 3 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвлөх, ментор багш ажлуулж багш солилцоо үйл ажиллагааг зохион байгуулах | | | | жилд: - Жилийн эцэст: 20 | ментор багштай аймгийн Засаг дарга гэрээ байгуулан ажиллаж 10-12-р ангийн хүүхдүүдэд хими, физик, математикийн хичээлээр нэмэлт сургалтуудыг зохион байгуулан 400 хүүхдийг хамруулан сургаж , ментор багш нарт 60.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. Тус багш нарыг ажлуулснаар 2023, 2024 онд Сүхбаатар аймаг ЭЕШ-тад улсад 1.2-р байранд жагссан. Зөвлөх зэрэгтэй 11 багш "Зөв-зөвлө-зөвлөх" клубыг байгуулан "Сургуулийн менежментийг сайжруулах" зөвлөн туслах баг сумдын сургуулиудад ажиллаа. 2024 онд Сүхбаатар аймгийн цэцэрлэгийн анхны Монгол Улсын Зөвлөх зэрэгтэй багштай болсон.<br>Хүрсэн түвшин: - | |
| 1.2.3 | Ахмад багш нарын зөвлөгөөн зохион байгуулах | 15,0 | Зөвлөгөөнд оролцсон ахмад багш нарын тоо | 0 | Эхний хагас жилд: 300 Жилийн эцэст: - | “Ахмад настны тухай” хууль, “Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт Ахмад настны талаар дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлж, бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлж, уламжлалт болон шинээр хөгжиж байгаа спортын төрлүүдийг ахмадуудын дунд түгээн дэлгэрүүлэх зорилгоор Аймгийн Засаг даргын нэрэмжит “Ахмад-2024” спортын олон төрөлт наадам зохион байгуулсан. Тус наадмыг Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу жил бүр дэмжин, зохион байгуулж ирсэн бөгөөд 13 сумын багуудын шилдэг 400 гаруй тамирчин ахмадууд спортын 8 төрлөөр өрсөлдсөн.<br>Хүрсэн түвшин: 400 | 70% |
| 1.2.4 | Англи хэлний | 30,0 | Багш, | 10 30 | Эхний | Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрчимжүүлсэн сургалт зохион байгуулах | | сурагчдын тоо | | хагас жилд: --- Жилийн эцэст: 15 60 | хүрээнд "Томужин Академи"-сургуультай хамтран төсөлд хамрагдаж байгаа 30 хүүхдэд эрчимжүүлсэн сургалтыг зохион байгуулан, 5,0 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн Засаг даргын 2024 оны А/128 дугаар захирамжаар шийдвэрлэсэн. Сүхбаатар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Дэлхийд өрсөлдөх Сүхбаатарчууд 10*10" төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа билээ. Уг хөтөлбөрийн хүрээнд АЗДТГ болон БШУГ-аас хамтран хичээллэж буй "One dream" Англи хэлний курс ийнхүү 2 дахь жилдээ үргэлжилж байна. Тус хөтөлбөрт 11- р ангийн 30 сурагч оролцож буй бөгөөд 12-р ангиа төгсөхдөө олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын оноонд хүрэх зорилт тавин суралцаж , тэдний 2023-2024 оны тасралтгүй сургалтын багшийн зардал 15,0 сая төгрөгийг орон нутгаас шийдвэрлэсэн.<br>Хүрсэн түвшин: 30 | |
| 1.2.5 | ЕБС, Цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар хангах | 3000 | Хамрагдсан байгууллагын тоо | ЕБС -2 Дотуур байр -2 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: - | Эрдэнэт ТӨҮГ-ын хөрөнгөөр 2023-2024 оны 2,3-р ээлжийн төсөлд 10 сумын 21 байгууламжаас цэцэрлэг-7, сургууль-6, дотуур байр-8 хамрагдахаас ашиглалтад цэцэрлэг-4, сургууль -4, дотуур байр - 5, нийт 13 байгууламж ашиглалтад оруулсан.<br>Хүрсэн түвшин: ЕБС - 4 Цэцэрлэг-4 Дотуур байр - 5 | 100% |
| 1.2.6 | Аймгийн нутгийн удирдлагын ордоны гадна монгол бичгээр гэрлэн хаяг , өрөөнүүдийн хаягыг хос | 5,0 | хаягжилтай болсон байгууллагын тоо , Өрөөний тоо | - | Эхний хагас жилд: Гадна хаягжилт - 1 Өрөөний тоо- -22 | Аймгийн засаг даргын тамгын газрын гадна гэрлэн хаяг болон 22 өрөөний хаягжилтийг 2024 оны 7 дугаар сард 3,900,000 төгрөгөөр хийлгэж байршуулсан.<br>Хүрсэн түвшин: Гадна хаягжилт - 1  Өрөөний тоо- - 22 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бичгээр бичиж байрлуулах | | | | Жилийн эцэст: - | | |
| 1.3. | Гэр бүл, хүүхдийн хөгжил хамгаалын үйлчлгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ | 1300,0 | Орчин нөхцөлөө сайжруулсан өрхийн тоо | 94 | 906 | Аймгийн Засаг дарга 2024.01.25-нд орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа банк болон ББСБ -уудтай уулзаж монгол гэрийн халаалт, дулаалга, агаар сэлгэлтийн чип багцыг хэрэглэх сонирхолтой иргэдэд зээл гаргаж өгөх талаар уулзалт хийж зөвшилцөлд хүрсэн. Баруун-Урт сумын багийн дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нар 90 хүнд 1 өдрийн сургалт мэдээллийг хүргэсэн. Мөн айл өрхөд тараагдах 4000 ш плакат хуудас, 1000ш гарын авлагыг хэвлүүлэн хэсгийн ахлагч нарт олгосон . "Сүхбаатарын өнгө" сонины тусгай дугаарт нэг нүүр мэдээллийг хэвлүүлж 1000ш хэвлэн иргэдэд нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. 5,6 -р сард 9 суман дээр очиж ажиллаж чип багцын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг хүргэсэн. нийт 270 иргэнд мэдээлэл хүргэсэн. 8,9-р сард чип багцын талаарх мэдээлэл сурталчилгааны ажлыг идэвхжүүлж, төв талбай гудамжид анонс, сурталчилгааны хуудас байршуулан, гэр мэдээллийн төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлж, чип багц авах нөхцөл шаардлага хангасан 150 иргэнийг зөв хэрэглээний сургалтад хамруулан, чип багцыг олгож гарын авлагаар хангав. Гүйцэтгэгч ХХК-иас 467 чип багцыг хүлээн авч иргэдэд олгох түгээх үйл ажиллагааг хийж байна. Орон нутгийн төсөвт тодотгол хийж гэр хорооллын цахилгаан эрчим хүчний хүчдэлийг нэмэгдүүлэх засварын ажлын төсвийг батлаж, худалдан авах үйл ажиллагааг зарлаж, гүйцэтгэгч ХХК шалгарч засварын ажлыг эхлүүлсэн. Тус засварын ажлын төсөвт өртөг 300,0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн. Орон нутгийн телевизэд 2 удаагийн ярилцлага, 14 удаагийн контент, мэдээллийг түгээсэн. 2023 онд 77 өрх, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 17 гэр цэцэрлэг, 2024 онд 212 өрх, 2 гэр цэцэрлэгт чип багц олгож 1300 хүн үр шимийг нь хүртэж байна. | |
| 1.3.1 | Зорилтот өрхийг гэрийн халаалт, дулаалга, агаар сэлгэлтийн чип багцаар хангах | 1300,0 | Чип багцад хамрагдсан өрхийн тоо | 77 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 812 | Аймгийн Засаг дарга 2024.01.25-нд орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа банк болон ББСБ -уудтай уулзаж монгол гэрийн халаалт, дулаалга, агаар сэлгэлтийн чип багцыг хэрэглэх сонирхолтой иргэдэд зээл гаргаж өгөх талаар уулзалт хийж зөвшилцөлд хүрсэн. Баруун-Урт сумын багийн дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч нар 90 хүнд 1 өдрийн сургалт мэдээллийг хүргэсэн. Мөн айл өрхөд тараагдах 4000 ш плакат хуудас, 1000ш гарын авлагыг хэвлүүлэн хэсгийн ахлагч нарт олгосон . "Сүхбаатарын өнгө" сонины тусгай дугаарт нэг нүүр мэдээллийг хэвлүүлж 1000ш хэвлэн иргэдэд нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. 5,6 -р сард 9 суман дээр очиж ажиллаж чип багцын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг хүргэсэн. нийт 270 иргэнд мэдээлэл хүргэсэн. 8,9-р сард чип багцын талаарх мэдээлэл сурталчилгааны ажлыг идэвхжүүлж, төв талбай гудамжид анонс, сурталчилгааны хуудас байршуулан, гэр мэдээллийн төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлж, чип багц авах нөхцөл шаардлага хангасан 150 иргэнийг зөв хэрэглээний сургалтад хамруулан, чип багцыг олгож гарын авлагаар хангав. Гүйцэтгэгч ХХК-иас 467 чип багцыг хүлээн авч иргэдэд олгох түгээх үйл ажиллагааг хийж байна. Орон нутгийн төсөвт тодотгол хийж гэр хорооллын цахилгаан эрчим хүчний хүчдэлийг нэмэгдүүлэх засварын ажлын төсвийг батлаж, худалдан авах үйл ажиллагааг зарлаж, гүйцэтгэгч ХХК шалгарч засварын ажлыг эхлүүлсэн. Тус засварын ажлын төсөвт өртөг 300,0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн. Орон нутгийн телевизэд 2 удаагийн ярилцлага, 14 удаагийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | контент, мэдээллийг түгээсэн. 2023 онд 77 өрх, 17 гэр цэцэрлэг, 2024 онд 212 өрх, 2 гэр цэцэрлэгт чип багц олгож 1300 хүн үр шимийг нь хүртэж байна.<br>Хүрсэн түвшин: 308 | |
| 1.3.1 | Залуучуудын хөгжил, оролцоог дэмжин ажиллана. | 30,0 | Үйл ажиллагааны тоо | 0 | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: 3 | Аймгийн хэмжээнд Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл-17, байгууллагын дэргэдэх залуучуудын зөвлөл-25 зөвлөл үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд байгууллагын дэргэдэх залуучуудын зөвлөлийн бүрэлдэхүүн, төлөвлөгөө, мэдээллийг албан бичиг хүргүүлэн авч нэгтгээд байна. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, зөвлөлийн гишүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээний удирдамж, хөтөлбөр, төсвийг боловсруулан зохион байгуулсан. Залуучуудад амьдрах ухааны сургалтыг зохион байгуулж, залуу гэр бүлд гэр бүлийн боловсрол олгох болон өсвөр үе, залуучуудад санхүүгийн боловсрол олгох, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зөвлөгөө өгч холбон зуучлах үйлчилгээ үзүүлэн давхардсан тоогоор 5099 иргэнд хүрч үйлчиллээ. Залуучуудын хөтөлбөрийн хүрээнд аян, сургалт, нөлөөллийн ажил, контент, подкаст, нэвтрүүлэг, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зэрэг нийт 22 арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 6155 иргэдэд хүрч үйлчилсэн.<br>Хүрсэн түвшин: 22 арга хэмжээ зохион байгуулсан. | 100% |
| 1.3.2 | Залуучуудын хөгжлийн төвийн дэргэд Юнител Хаб төвийг | 5 | ХАБ төвөөр үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо | 0 | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: | Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого"-той уялдуулан "Бизнесийн сэргэлт" хөтөлбөрийг хэрэгжүүлж, 10000 залуучуудыг Бизнесийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | | | | 300 | богино сургалтад хамруулах, 1000 залууг Олон Улсын бизнесийн сургалтад хамруулсан. Уг хөтөлбөрт Сүхбаатар аймгаас 300 залуучуудыг хамруулсан бөгөөд Сургалт 12 сэдвийн хүрээнд явагдсан. Юнител Хаб төв нь аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дэргэд байгуулагдаж байгаа ба өрөөний засвар үйлчилгээ хийгдэж дуусаад байна.<br>Хүрсэн түвшин: Юнител Хаб төвийн үйл ажиллагаа тогтмолжсон байна. "Бизнесийн сэргэлт" хөтөлбөрт аймгийн хэмжээнд 300 залуучуудыг сургалтад хамруулсан. | |
| 1.4. | Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ. | 3020,0 | Шинээр бий болсон ажлын байрны тоо | 1103 | 1000 | ймаг, сумдын Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сайн дурын даатгалын хамрагдалтын төлөвлөгөөг тусгаснаас гадна аймгийн хэмжээнд “Сайн даатгагч багийн Засаг дарга” болзолт уралдааныг сумдын Засаг даргын захирамж захирамжаар зарлаж хагас бүтэн жилээр үр дүнг тооцож ажиллаж байна. 2024 оны байдлаар 4299 иргэнийг сайн дурын даатгалд хамруулсан байна. Үүнээс хувиараа хөдөлмөр эрхлэгч 1210, малчин 2282, хүүхдээ асарч буй эх 712, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч буй эх /эцэг/, асран хамгаалагч 95 хүнийг сайн дурын даатгалд хамруулсан. Шинээр 2764 иргэн сайн дурын даатгалд хамрагдсан нь төлөвлөгөө хангалттай сайн биелсэн.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулах танхимын мэргэжил олгох сургалтын хэрэгцээний судалгааг аймгийн хэмжээнд цахимаар авч судалгааны үндсэн дээр орон нутагт хэрэгцээтэй байгаа цахилгаанчин болон талх нарийн боов үйлдвэрлэлийн чиглэлээр зохион байгуулсан. Суурь ур чадвар олгох сургалтад ажил хөдөлмөр эрхлээгүй хөдөлмөрийн насны 80 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэнд 3 хоногийн суурь чадамж олгосон. “Эрэлтэл нийцсэн ур чадвар олгох” хөтөлбөрийн хүрээнд 20 мэргэжлийн дагуу 21 иргэн хамрагдсан. Хөдөлмөр эрхлэлтэд 84 иргэнийг байнгын ажлын байранд, 332 иргэнийг түр ажлын байранд, төсөл хөтөлбөрт 52 иргэнийг тус бүр ажиллуулсан. | |
| 1.4.1 | Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийг боловсруулж, холбогдох талуудтай байгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах | - | Хэлэлцээрийг байгуулж, бүртгүүлсэн эсэх | 1 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм"-ийг үндэслэн аймгийн хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийг аймгийн засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/40 дүгээр захирамжаар шинэчлэн байгууллаа. Тус зөвлөл нь 2024 он дөрөвдүгээр улирлын байдлаар 3 удаа хуралдаж хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжиж буй хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулах хийж хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцэж шийдвэрлээ.<br>Хүрсэн түвшин: 3 | 100% |
| 1.4.2 | “ХАБЭА-н сарын аян-2024” арга хэмжээг зохион байгуулж, эрүүл, аюулгүй ажлын байрыг бий болгох чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн | 3000 | Зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээний тоо | 6 | Эхний хагас жилд: 7 Жилийн эцэст: - | Сарын аянаар байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтны эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох, ажлын байран дахь осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл болон бусад эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н хүрээнд сайн туршлагыг судлах, түгээн дэлгэрүүлэх, нэвтрүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтнуудад мэдлэг олгох сургалтыг үе шаттай зохион байгуулж, хөдөлмөрийн харилцаа, ХАБЭА-н тухай хууль, тогтоомж, дагаж гарсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулах | | | | | дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгөх арга хэмжээнүүдийг болсон.<br>Хүрсэн түвшин: 7 | |
| 1.4.3 | Нийгмийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулах | - | нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан даатгуулагчийн тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 2023 оны түвшнээс 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ | Аймаг, сумдын Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд сайн дурын даатгалын хамрагдалтын төлөвлөгөөг тусгаснаас гадна аймгийн хэмжээнд “Сайн даатгагч багийн Засаг дарга” болзолт уралдааныг сумдын Засаг даргын захирамж захирамжаар зарлаж хагас бүтэн жилээр үр дүнг тооцож ажиллаж байна. 2024 оны байдлаар 4299 иргэнийг сайн дурын даатгалд хамруулсан байна. Үүнээс хувиараа хөдөлмөр эрхлэгч 1210, малчин 2282, хүүхдээ асарч буй эх 712, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч буй эх /эцэг/, асран хамгаалагч 95 хүнийг сайн дурын даатгалд хамруулсан. Шинээр 2764 иргэн сайн дурын даатгалд хамрагдсан нь төлөвлөгөө хангалттай сайн биелсэн.<br>Хүрсэн түвшин: 4299 шинээр 2764 | 100% |
| 1.4.4 | Халамжаас хөдөлмөрт арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгийн иргэдийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах | - | Хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлсэн өрхийн тоо | 250 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 250 | Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулах танхимын мэргэжил олгох сургалтын хэрэгцээний судалгааг аймгийн хэмжээнд цахимаар авч судалгааны үндсэн дээр орон нутагт хэрэгцээтэй байгаа цахилгаанчин болон талх нарийн боов үйлдвэрлэлийн чиглэлээр зохион байгуулсан. Талх нарийн боов үйлдвэрлэлийн сургалтыг 1 сарын хугацаанд “Мөнх алтан хүлэг” сургалтын байгууллагатай хамран зохион байгуулж 27 иргэн хамруулан чадамжийн гэрчилгээ олгоод байна. Сургалтад хамрагдсан иргэд гэрээр үйлдвэрлэл явуулж байна. Аймгийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран 1 сарын хугацаанд “Цахилгаанчин” мэргэжлээр сургалт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулж 19 иргэн хамрагдаж нийт 46 иргэн мэргэжил олгох сургалтад хамрагдаад байна. Эм эс девелопмент консалтинг сургалтын байгууллагатай хамтран хөдөлмөрт бэлтгэх сургалтын суурь ур чадварын сургалт болон АМЧБОлгох сургалт зөвлөгөөг зохион байгуулсан. Суурь ур чадвар олгох сургалтад ажил хөдөлмөр эрхлээгүй хөдөлмөрийн насны 80 иргэнд 3 хоногийн суурь чадамж олгосон. “Эрэлтэл нийцсэн ур чадвар олгох” хөтөлбөрийн хүрээнд 20 мэргэжлийн дагуу 21 иргэн хамрагдсан. Хөдөлмөр эрхлэлтэд 84 иргэнийг байнгын ажлын байранд, 332 иргэнийг түр ажлын байранд, төсөл хөтөлбөрт 52 иргэнийг тус бүр ажиллуулсан.<br>Хүрсэн түвшин: 332 | |
| 1.4.5 | Аймгийн Ахмадын бага чуулганыг зохион байгуулна. | 15,0 | Чуулганд оролцсон ахмадын тоо | - | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: 60-аас доошгүй ахмад настанг хамруулсан байна | Аймгийн ахмадын бага чуулганыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд аймгийн ахмадын хороо сумдын ахмадын хорооны дарга удирдлагуудын нэгдсэн хуралдааныг аймгийн төвд зохион байгуулж өнгөрсөн онд хийж хэрэгжүүлсэн ажлаа дүгнэж сумдын ахмадын хороо болон албан байгууллагуудыг шалгаруулахаар төвлөн ажиллаж байна. “Ахмад настны тухай” хууль, “Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт Ахмад настны талаар дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлж, бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлж, уламжлалт болон шинээр хөгжиж байгаа спортын төрлүүдийг ахмадуудын дунд түгээн дэлгэрүүлэх зорилгоор Аймгийн Засаг даргын нэрэмжит “Ахмад-2024” спортын олон төрөлт наадам зохион байгуулсан. Тус | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | наадмыг Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу жил бүр дэмжин, зохион байгуулж ирсэн бөгөөд 13 сумын багуудын шилдэг 400 гаруй тамирчин ахмадууд спортын 8 төрлөөр өрсөлдсөн.<br>Хүрсэн түвшин: 400 | |
| 1.4.6 | Аймгийн төвийн нийтийн зориулалттай барилга байгууламжид хүртээмжийн нэгдсэн үзлэг зохион байгуулах | 5,0 | Үзлэгт хамрагдсан байгууллагын тоо | - | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 30-с доошгүй | Засгийн газрын 212 дугаар тогтоолын дагуу “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс”-н бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийн оролцоог хангаж 960 хүүхдийн сургуулийн барилга, Баян шарга 2 хотхон, Тэмүүлэл хотхон, Хос өргөө орон сууц, спорт цогцолбор, Түмэнцогт, Сүхбаатар сумын дотуур байр зэрэг 10 барилгыг хүлээн авсан. Мөн өмнө ашиглалтад орсон 12 барилга, байгууламжид үнэлгээ хийж, иргэд зорчих, үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх талаар зөвлөгөө өгсөн.<br>Хүрсэн түвшин: 22 | 90% |
| 1.5. | 2024 оны төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах | 2800,0 | Хууль тогтоомжийн хүрээнд төсөв хэрэгжсэн эсэх. | Тийм | Тийм | Аймаг сумдын 2024 оны төсвийн жил , сарын батлагдсан хуваарийг төсвийн төлөвлөлтийн программд сум, байгууллага тус бүрээр эдийн засгийн ангилалаар оруулж , аймгийн нэгдсэн баазыг Сангийн яаманд хянуулан Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд нийт 12 удаа татуулж ажилласан. Аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн дүн 112,015.1 сая төгрөг. Сумд, байгууллагуудаас ирүүлсэн 2024 оны төсвийн хуваарийн саналыг хянан, нэгтгэн боловсруулж Аймгийн Засаг даргын 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 тоот захирамжаар аймгийн төсвийн сар улирлын хуваарийг батлуулсан. Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 23 дугаар хурлаар батлагдсан "Аймгийн 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай " 01 тоот | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтоолын дагуу Аймгийн Засаг даргын 2024 оны 5 дугаар сарын 03 -ны өдрийн А/261 тоот захирамжаар аймгийн төсвийн сар улирлын хуваарийг шинэчлэн батлууллаа. -Аймаг сумдын 2024 оны төсвийн жил , сарын батлагдсан хуваарийг төсвийн төлөвлөлтийн программд сум, байгууллага тус бүрээр эдийн засгийн ангилалаар оруулж , аймгийн нэгдсэн баазыг Сангийн яаманд хүргүүлсэн. Аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн дүн 112,015.1 сая төгрөг. --Өвөлжилт хүндэрч гамшгийн байдалд хүрсэнтэй холбоотойгоор төсвийн хуваарьтаа өөрчлөлт оруулж зохицуулалт хийсэн АЗДТГ болон Баруун-Урт , Түвшинширээ, Дарьганга, Уулбаян, Асгат, Баяндэлгэр, Түмэнцогт , Наран, Мөнххаан , Халзан , Онгон , Эрдэнэцагаан сумдын төсвийн баазыг шалгаж, мөн батлагдсан төсөвтөө зохицуулалт хийлгэхээр хүсэлт ирүүлсэн аймгийн ИТХ-ын ажлын алба, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны хүсэлтийг шийдвэрлэж, аймгийн нэгдсэн баазыг Сангийн яаманд нийт 10-н удаа татуулж ажилласан. Санхүүгийн дэмжлэг болон ААНОАТатварын хуваарьт өөрчлөлт оруулах тухай албан хүсэлтийг Сангийн яамны төсвийн бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлснээр санхүүгийн дэмжлэгийн хуваарийг урагшлуулсан. | |
| 1.5.1 | 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд төсвийг бүрдүүлэх, хуваарилах, зохицуулалт хийх, шаардлагатай тохиолдолд | - | Хэрэгжилтийн хувь | 100 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100 | 1. Сумд, байгууллагуудаас ирүүлсэн 2024 оны төсвийн хуваарийн саналыг хянан, нэгтгэн боловсруулж Аймгийн Засаг даргын 2024 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 тоот захирамжаар аймгийн төсвийн сар улирлын хуваарийг батлууллаа. 2. Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 23 дугаар хурлаар "Аймгийн 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай " 01 тоот тогтоол батлагдсан бөгөөд дээрх өөрчлөлтийн хүрээнд Аймгийн Засаг даргын 2024 оны 5 дугаар сарын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төсвийн тодотголыг боловсруулах, батлуулах замаар төрийн үйлчилгээг тасралтгүй хүргэх. | | | | | 03 -ны өдрийн А/261 тоот захирамжаар аймгийн төсвийн сар улирлын хуваарийг шинэчлэн батлуулллаа 3. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон орон нутгийн төсөвт үүссэн зарим нөхцөл шаардлага, хүлээгдэж буй гүйцэтгэл зэргийг үндэслэн 2024 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 19-р хуралдаанаар аймгийн 2024 оны төсвийн өөрчлөлтийг хэлэлцэн баталсан бөгөөд аймаг, сумдын тодотгосон төсвийн хуваарийг боловсруулж аймгийн Засаг даргын А/583 тоот захирамжаар батлууллаа.<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 1.5.2 | Аймгийн төрийн сан болон сумдын ЗДТГ-ын Санхүүгийн албаны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллах. | 2,000,0 | Дотоод хяналтын төлөвлөгөөний биелэлтийн хувь | 90 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100 | Сумдын ЗДТГ-ын Санхүүгийн албанаас Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам"-ын хавсралтаар батлагдсан 2024 оны үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээг хийсэн тайланг нэгтгэн 2024 оны эрсдэлийн нэгдсэн тайланг гарган СЯ-ны ТТГ-т цахимаар болон цаасаар хүргүүлэн ажилласан. Эрсдэлийн нэгдсэн үнэлгээгээр 10 буюу төрийн сангийн үйл ажиллагаа бага эрсдэлтэй гэж гарсан.<br>Хүрсэн түвшин: 100 | 100% |
| 1.5.3 | 2024 оны төсвийн гүйцэтгэлийн зохион байгуулалт, хууль тогтоомжийн шинэчлэл сургалт | 800,0 | Сургалт зохион байгуулагдсан эсэх | 1 | Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: - | -2024.03.14-ний өдөр Сумдын ЗДТГ-ын Санхүүгийн албатай 2024 оны Үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулах, төрийн сангийн үйл ажиллагаанд цаашид анхаарах асуудлууд сургалтыг зохион байгуулсан. -Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын талаарх танилцуулга болон бусад мэдээ мэдээлллийг сумдын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга нарт цахимаар 2 удаа зохион байгуулсан. Сургалтыг 5 дугаар сарын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 29-ний өдөр, 9 сарын 13 -ний өдрүүдэд тус тус зохион байгуулсан. -2024.10.24-ны өдөр Ажил олгогч нарт НД-ын хууль тогтоомжийн мэдлэг олгох зөвлөгөөн, 2024.10.30-ны өдөр Соёл урлагийн байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарыг чадавхижуулах сургалтад оролцож төсөвт байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт *Төрийн сангийн цахим системийн хөгжүүлэлтүүд, төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой анхаарах асуудлууд* сэдвээр 15минутын илтгэл тавьж мэдээлэл хүргэв.<br>Хүрсэн түвшин: 3 | |
| 1.5.4 | Орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагууд ын санхүүгийн тайланг хүлээн авч хянан баталгаажуулж хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлэх. | - | Хянан баталгаажуулал тын хувь | 95 | Эхний хагас жилд: 95,2 Жилийн эцэст: - | 2023 оны жилийн эцсиийн байдлаар 1081 ААНБ санхүүгийн тайлан тушаахаас 895 ААНБ хуулийн хугацаандаа, 5 ААНБ тайлангаа хоцроон илгээсэн байна. 181 ААНБ тайлан огт ирүүлээгүй. Тайлан илгээсэн ААНБ-уудааас 305 нь огт үйл ажиллагаа явуулаагүй гэж Х тайлан тайлагнасан . Санхүүгийн жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор цахимаар хүлээн авах хуулийн заалттай хэдий ч тайлант онд Сангийн яамнаас санхүүгийн И-Баланс системийг шинэчилсэнтэй холбоотойгоор 2 дугаар сарын 23-ныг дуустал сунган ААНБ-уудаас тайланг хүлээн авлаа. Шинэ системдээ бүртгэл хийгээгүй болон тайлан шивээгүй ААНБ-ын нягтлан бодогч, удирдлагуудтай тухай бүр холбогдон ажилллаа. Тайлангийн явцад 4344 удаа санхүүгийн тайлантай холбоотой баталгаажуулалт, буцаалт, холбох хүсэлт, засвар хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Тайлан ирүүлсэн ААНБ-уудыг өмчийн хэлбэр, шинж чанараар нь харуулбал: 21 ОНӨҮААТҮГ , 614 ХХК , 54 нөхөрлөл , 61 хоршоо , 134 ТББ , 1 Сан , 8 шашны байгууллага ,5 ББСБ, 2 ХЗХ тус тус | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайлан байна. Аудит хийлгэвэл зохих НАСБ 108 байгаагаас 92 ААНБ нь тайлангаа аудитаар баталгаажуулан илгээлээ. Тайлангийн ирц 83,3%. Сангийн сайдтай байгуулсан гэрээний заалтад тусгагдсан санхүүгийн тайлангийн ирцийн гүйцэтгэлийн хувийг 104 хувиар давуулан биелүүллээ. 475 аж ахуй нэгж байгууллага санхүүгийн тайлангаа алдаатай тайлагнасан. Алдаатай тайлангууд бүгд буцаагдсан ба байгууллагуудын нягтлан бодогч бүртэй тус бүрд нь холбогдон тайлангийн алдааг хэлж, арга зүйн зөвлөгөөг өгч тайланг засуулан, баталгаажууллаа. Мөн сумдын төрийн сангийн мэргэжилтэнтэй хамтран тухайн суманд үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын удирдлага, нягтлан бодогчдыг мэдээллэл зөвлөгөөгөөр хангаж тайлангийн чанар, ирцийн зорилтот түвшинд хүрэхэд хамтран ажиллалаа. 2023 онд Сүхбаатар аймгийн хэмжээнд 112 ААНБ шинээр үүсгэн байгуулагдсан бол 6 ААНБ татан буугдан үйл ажиллагаагаа зогсоосон байна. Сангийн яамнаас 500 ААНБ-ын санхүүгийн тайланг буцаасан ба засварлуулан хүлээн авах ажил 95 хувьтай явагдаж байна.<br>Хүрсэн түвшин: 95 | |
| 1.6. | 2025 оны төсвийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх | - | Хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн эсэх | Тийм | Тийм | 1. Сумд, байгууллагуудаас ирүүлсэн 2025 оны төсвийн зарлагын саналыг хянаж, төсвийн төлөвлөлтийн Fiscal программд байгууллага, хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал нэг бүрээр оруулж, аймгийн нэгтгэсэн дүнг гарган баазыг Сангийн яаманд татуулсан. 2. Сангийн яамны хариуцсан мэргэжилтэнгүүдтэй уулзаж, холбогдох нэмэлт судалгаа тооцооллыг гаргаж өгсөн. / Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан ТЖАХаагчийн 5-н жилийн тэтгэмжийн судалгаа, Тэтгэвэрт гарах ажиллагсадын судалгаа, Улсын төсвийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагуудын төрийн албан хаагчдын судалгаа, Тогтмол зардлын судалгаа гэх мэт/ 3. Аймгийн орон нутгийн төсвийн байгууллагуудын орон тоо, цалингийн сангийн дэлгэрэнгүй судалгааг нэмэлтээр гаргаж, холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. 4. Төслийн хүрээнд зарлагдсан “ОРОН НУТАГТ ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭГДСЭН УДИРДЛАГЫГ ХЭВШҮҮЛЭХ НЬ” дэмжих хөтөлбөрт ЗДТГ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдхүүнд орж хамрагдан, аймгийн орон нутгийн 2025 оны төсвийн төслийн саналыг үр дүнд суурилсан төсөвлөлт-ийн арга, аргачлалыг ашиглан боловсруулж, холбогдох материалыг төслийн багт заасан хугацаанд хүргүүлсэн. | |
| 1.6.1 | Аймгийн 2025 оны төсвийн төслийн саналыг боловсруулж аймгийн ИТХурлаар хэлэлцүүлэн батлуулах. | - | Хуулийн хугацаанд төсөв батлагдсан эсэх | Тийм | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Тийм | Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд аймгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулан, саналыг холбогдох тооцоолын хамт Аудитын газарт хүргүүлж ажилласан. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон дагалдах бусад хуульд тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал хүлээн авч, тус хуулиудыг хүчингүй болгосноор Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг Засгийн газар УИХуралд дахин өргөн мэдүүлээд байна . Энэ хүрээнд аймгийн төсвийн төслийг дахин боловсруулж, тооцооллыг хийн ажиллаж байна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль эцэслэн батлагдаагүй байна.<br>Хүрсэн түвшин: тийм | 90% |
| 1.7. | Иргэн, хуулийн этгээдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх | 500,0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | 3 | ЗГ-ын тогтоолоор батлагдсан 2023 оны 444 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн сангийн төлбөр тооцоог ТСУЦС болон ЗГСУМС-д түргэн шуурхай дамжуулан ажиллаж байна. ТСУЦС-д | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 8,305 гүйлгээг /нийт 49,4 тэрбум төгрөг/ банк хооронд дамжуулсан, 146 гүйлгээг /нийт 1,2 тэрбум тбгрбг/ анхан шатны баримт дутуу, хөтөлбөр зориулалт буруу, мөнгөн дүн зөрүүтэй зэргээр буцаан буюу цуцалж ажилласан байна. Банкны систем болон төрийн сангийн системд алдаа гарсантай холбоотой 43 гүйлгээ буцсан бөгөөд тухайн гүйлгээг дахин илгээхийг байгууллагуудад хэлэн залруулгыг хийн ажилласан байна. ТСУЦС-д ТУНС-д бүртгэлгүй харилцагч /18 нас хүрээгүй хүүхэд, ахмад настан/-ийг гараас бүртгэх, ТАЦНС-ийн гүйлгээнд нэмэлт анхан шатны баримт хавсаргадаг болсон зэрэг шинэчлэлүүд хийгдсэн. 2-р улиралд ТСУЦС-д зарлагын модуль шүүлт хийх, нэхэмжлэх модуль мөнгөн дүнг үсгээр илэрхийлэх, үүссэн төлөвт байгаа нэхэмжлэхийг буцаах, үлдэгдэл баганаар харуулах, хялбаршуулсан гүйлгээ хийхэд РД, данс давхардахгүй зэрэг хөгжүүлэлт хийгдсэн байна. ТСУЦС-д хяналтын дэлгэц, төсөвт байгууллагаас нэмэлт санхүүжилт болон зарлагын хүсэлт зэргийг цахимаар авдаг болох, гүйлгээний төлбөрийн хүслэтийг хувилах, өмнөх гүйлгээний үндсэн бармитыг дараагийн гүйлгээнд холбох, зарлага гүйлгээ хувилах, хялбаршуулсан гүйлгээнд харилцагчийн мэдээллийг эксэл файлаас хуулж оруулах зэрэг хөгжүүлэлтүүд хийгдэж байгаа. | |
| 1.7.1 | Иргэдэд хөрөнгийн болон бусад үүсмэл санхүүгийн зах зээлийн талаархи мэдлэг олгох, санхүүгийн | 500,0 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 3 | Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хууль батлагдсантай холбоотой зохицуулалттай байгууллагууд дүрмийн сангаасаа хамааран СЗХ, нийслэл болон АЗД-аас зөвшөөрлөө авах болсон. Нэткапитал ХХК болон түүний салбар болох 5 аймаг, 2 дүүрэг зөвшөөрөл аван үйл ажиллагаа явуулж байна. NIBank-наас бэлтгэн гаргадаг хүүхдийн санхүүгийн боловсролд багаас нь мэдлэг олгох, санхүүгийн сахилга | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсролыг дээшлүүлэх. | | | | | батыг суулгахад чиглэгдсэн цахим контент, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргаж буй мөнгөн зээлийн үйл ажиллагааны талаарх контент болон бусад санхүүгийн чиглэлийн контентүүдийг хэлтсийн цахим хуудаст байршуулан ажиллаж байна. /https://www.facebook.com/profile.php?id=100090797783648/ Цахим гэмт хэрэг, мөнгө угаалт, койны талаарх мэдээллийн орон нутгийн цахим мэдээллийн хэрэгслээр 8 удаагийн видео шторк, 19 удаагийн мэдээлэл, гарын авлагыг давхардсан тоогоор 1872 иргэн, хуулийн этгээдэд хүргэсэн байна. Санхүүгийн зохицуулах хорооноос зүүн бүсийн аймгуудын хуулийн этгээд, иргэдийг хамруулан мөнгөн зээлийн үйл ажиллагааны болон үнэт метал эзэмшигчийн эрх үүрэг, үнэт металыг хэрхэн таних ялгах талаар цахим сургалтыг амжилттай зохион байгууллаа. Мөн иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулж буй хөрөнгийн зах зээлийн анхан шатны мэдлэг, мэдээлэл олгох 2 өдрийн цахим сургалтад 7 иргэнийг хамруулан оролцлоо.<br>Хүрсэн түвшин: Санхүүгийн зохицуулах хороотой хамтран 4 удаагийн цахим санхүүгийн боловсрол олгох сургалтыг зохион байгууллаа. | |
| 1.8. | Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх | 2,0 тэрбум | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | 20 | 35 | Орон нутгийн бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, туршлага судлуулах зорилгоор "Цагаан сар-2024" улсын үзэсгэлэн худалдаанд 5, "Сүхбаатарт үйлдвэрлэв- Бидний хэрэглээ-2024" орон нутгийн цагаан үзэсгэлэн худалдаанд 54, “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд 3, Орхон аймагт зохион байгуулагдсан “Улсын аварга бренд хоол, идээ ундааны ур чадварын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уралдаан, спортын анхдугаар наадам"-д 25, "Зүүн бүсийн үсчин гоо сайханчдын аварга шалгаруулах" уралдаанд 18, "Орон нутгийн онцлог бүхий бренд хоол хөгжүүлэх аймгийн аварга тогооч шалгаруулах" тэмцээнд 150 , Бэст төслийн бизнес төсөл боловсруулах, урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлд хамрагдахад анхаарах зүйлсийн хүрээнд давхардсан тоогоор 35 бизнес эрхлэгч иргэн, аж ахуй нэгж, сүү, цагаан идээ боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчид, хоршоодын 40 төлөөллийг Өвөр Монголын өөртөө засах орны "Шилийн гол" аймагт сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэр, фермийн үйл ажиллагаатай танилцах туршлага судлах аялалд тус тус хамруулсан. Салбарын хүний нөөцийг чадавхжуулах 8 удаагийн арга хэмжээнд нийт 500 бизнес эрхлэгчдийг хамруулж, 35 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж ажилласан. | |
| 1.8.1 | Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх улс, орон нутгийн бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг хангах | 1,5 тэрбум | Дэмжлэг үзүүлсэн аж ахуй нэгжийн тоо Зөвлөх үйлчилгээ, сургалтанд хамрагдсан бизнес эрхлэгчдийн тоо | 60 80 | Эхний хагас жилд: 14 50 Жилийн эцэст: 50 50 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээс зээл олгох мэдээллийг 1 сарын хугацаатай олон нийтэд ил тод нээлттэй зарлаж, нийт 22 аж ахуй нэгжийн 2,7 тэрбум төгрөгний бизнес төсөл хүлээн авсан. Холбогдох журмын дагуу 3 шатны шалгуур хангасан 12 аж ахуй нэгжийн 1,5 тэрбум төгрөгийн төслийг аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн А/305 дугаар Захирамжаар байгуулагдсан орон нутагт төсөл сонгон шалгаруулах дэд хорооны хурлаар хэлэлцүүлж, тэргүүн ээлжинд санхүүжих 10 төсөл, эх үүсвэр үлдсэн тохиолдолд санхүүжих 2 төслийн жагсаалтыг аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн А/334 дүгээр захирамжаар баталгаажуулан Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх газарт хүргүүлж ажилласан. Ингэснээр 11 төсөл нийт 1,4 тэрбум | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийн санхүүжилт авч төслийн үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагын Бэст төслийн Дорнод салбарт санал тавьж ажилласнаар урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэл бүхий 35 аж ахуй нэгжид бизнес төсөл боловсруулах, төсөл сонгон шалгаруулах үе шатуудад анхаарах зүйлсийн талаар 2 удаагийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд сүү, цагаан идээ боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй малчид, хоршоодын 40 төлөөллийг Өвөр Монголын өөртөө засах орны "Шилийн гол" аймагт сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэр, фермийн үйл ажиллагаатай танилцах туршлага судлах аялалд 6 сая төгрөгийг ЗДҮАХ хэрэгжүүлэх зардлаас шийдвэрлүүлэн хамруулсан. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран бараа бүтээгдэхүүний патентын эрх, түүний ач холбогдол сэдвээр 15 үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуй нэгжид зөвлөх үйлчилгээ үзүүлж, бараа бүтээгдэхүүн дээр биечилсэн зөвлөгөө өгч ажилласан. Үүний үр дүнд “Миний өөшгөө” ХХК-ийн Дарьганга хийцтэй цай бүтээгдэхүүний Дарьганга эхнэр, дөрвөлжин монгол бичиг, эвхмэл бичиг гэсэн 3 барааны тэмдэгтийн патентыг баталгаажуулсан. Үүнд ЗДҮАХ хэрэгжүүлэх зардлаас 1,5 сая төгрөгийг шийдвэрлэсэн.<br>Хүрсэн түвшин: 90 | |
| 1.8.2 | Орон нутагт Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг | 300,0 | Дэмжлэг үзүүлсэн аж ахуй нэгжийн тоо | 3 | Эхний хагас жилд: 3<br>Жилийн эцэст: 3 | Хүн амын хаврын махны нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд Баруун-Урт суманд мах боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Дарьт шүтээн ХХК, Өндөр хамар хоршоо, Түмэн цагаан хоршоотой эрүүл ахуй, аюулгүй байдал хангасан махны нөөц бүрдүүлэх гэрээ хийх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах | | | | | ажлыг зохион байгуулсан. Тус 3 ААН-тэй Хүнс, хөдөө аж ахуйн газар гэрээ хийж нийт 40,0 тонн махыг бэлтгэн нөөцөлж 2024 оны 04-06 дугаар саруудад өөрсдийн нэрийн дэлгүүр болон үйлдвэрлэлийн байран дээрээс зах зээлд худалдан борлуулсан. Аймгийн өвөл хаврын хүнсний хангамжийн нөөцөд зориулц 5548 тонн мах бэлтгэсэн.<br>Хүрсэн түвшин: 3 ААН 40 тонн | |
| 1.8.3 | Малын үйлдвэрлэг байдал ашиг шимийн гарц, чанарыг сайжруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангах | - | Үзлэг ангилалтад хамрагдсан малын тоо | 13500 | Эхний хагас жилд: 0 Жилийн эцэст: 13550 | Энэ онд нийт 18393 малд үзлэг ангилалт хийгдсэн. Үүнээс 270 толгой малыг цөм сүрэгт бүртгэснээр 6787 толгой баталгаажсан үүлдэр, омгийн малтай болсон.<br>Хүрсэн түвшин: 18393 | 100% |
| 1.8.4 | Атаршсан газрын талбайн ашиглалтыг сайжруулан, тариалалтыг нэмэгдүүлнэ | - | Тариалсан талбайн хэмжээ га-аар | 9242 | Эхний хагас жилд: 0 Жилийн эцэст: 9300 | Үр тарианы хувьд 2024 онд аймгийн хэмжээнд овъёос 755 га-аас 627,5 тн, арвай 281 га-аас 252 тн, улаан буудай 2527 га-аас 1637 тн, рапс 3220 га-аас 878 тн нийт 6783 га-д тариалж 3395 тн хураан авсан. Улаан буудайн тариалалт өмнөх оноос 1,0 га-аар буурч, овьёос 0,9 га, рапс 0,2 га-аар нэмэгдсэн байна. Энэ онд орон нутгийн хэмжээнд 74 га талбайд төмс, 51,39 га талбайд хүнсний ногоо тариалж төмс 490,5 тн, хүнсний ногоо 813,25 тн ургац хураан авсан. Энэ нь хүн амын хэрэгцээт төмсний хангамжийн 25,9 хувь, хүнсний ногооны хангамжийн 20,7 хувьд хүрсэн.<br>Хүрсэн түвшин: 9 | 100% |
| 1.8.5 | Мал, амьтныг гоц халдварт болон | - | Арга хэмжээний тоо | - | Эхний хагас жилд: 1 | Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шүлхий, цэцэг, мялзан өвчний дархлаажуулалтад давхардсан тоогоор 3.2 сая | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад бүрэн хамруулах арга хэмжээг зохион зохион байгуулах | | | | Жилийн эцэст: 3 | малыг 759.7 сая төгрөгөөр, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 7 нэрийн вакцинд 956.2 мянган малыг 308.0 сая төгрөгөөр тус тус хамруулж нийт 1067.7 сая төгрөгийн үнэтэй вакцинаар 4.1 сая малыг дархлаажуулж 587.0 сая төгрөгийг үйлчилгээний хөлсөд зарцуулсан. Үүнээс орон нутгийн төсвөөс 416.0 мянган малыг дуут, цусан халдварт, ДХХ-энтериобактериоз зэрэг вакцинд 170.2 сая төгрөгөөр дархлаажуулж, 455.0 сая төгрөгийг үйлчилгээний хөлсөд зарцуулсан.<br>Хүрсэн түвшин: 3 | |
| 1.9. | Батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтйиг зохион байгуулах | 65239,6 сая төгрөг 127 ТАХ | Нийт хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо хэрэгжилтийн хувь | 75 | 85 | 2024 онд эрх шилжин хэрэгжиж буй 21 ТАХ, санхүүжих дүн 28787,3 сая төгрөг батлагдсан. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 24002,6 сая төгрөгийн зарлага санхүүжилт буюу 83,3 хувийн хэрэгжилттэй. 8 ТАХ бүрэн дуусч 2024 онд батлагдсан санхүүжилтээ бүрэн авна. Баяндэлгэр сумын 150 хүүхдийн цэцэрлэг, Өвлийн хүлэмжний тендер зураг төсөл бэлэн болоогүйгээс оройтож зарлаж, гэрээ байгуулагдсан тул дээрхи 2 төслийн 2024 онд батлагдсан санхүүжилтийг авч чадаагүй. УТХО-ын гүйцэтгэл 100 хувь цахим системээр явагдаж байна, 2024 онд санхүүжигдээгүй үлдэгдэл хөрөнгийг ЗГ тогтоол гарвал дундын буюу барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Аймгийн хөрөнгө оруулалтаар 126 төсөл арга хэмжээ батлагдсан. Үүнээс шилжих 75 төсөл арга хэмжээ шинээр 51 төсөл арга хэмжээ тусгагдсан байна. Шинэ 47 төсөл арга хэмжээнд гүйцэтгэгч тодорч, 1 төсөл арга хэмжээ зураг төсөв бэлэн болоогүйн улмаас зарлагдаагүй, 1 ТАХ орон нутгийн орлого тасалдсантай холбоотой хойшлогдож 2 төсөл арга хэмжээний тендер улирлын онцлогоос шалтгаалан зарлагдаагүй хүлээгдэж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна. Хэрэгжилт 92,1 хувьтай байна. Жилийн эцсийн байдлаар 69 төсөл арга хэмжээнд 11,636.2 сая төгрөгийн санхүүжилт олгон ажилласан. | |
| 1.9.1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг зохион байгуулах | 35247,5 сая төгрөг | хэрэгжилтийн хувь | 83 | Эхний хагас жилд: 30 Жилийн эцэст: 85 | УТХО-аар Шинээр эрх шилжин хэрэгжсэн 14 төсөл арга хэмжээ, 2024 онд санхүүжих дүн 21282,8 сая төгрөг батлагдсан. Үүнээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 12 төсөл арга хэмжээний 17557,7 сая төгрөгийн санхүүжилтийг хянаж, санхүүжүүлэхээр байна. Санхүүжилтийн гүйцэтгэл 82,5 хувийн хэрэгжилттэй. Баяндэлгэр сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын 1443,6 сая төгрөг, Хүнсний ногооны зоорийн 284,0 сая төгрөг, Онгон сумын 300 суудалтай соёлын төвийн барилгын 867,0 сая төгрөг, Дарьганга зуслангийн инженерийн шугам сүлжээний 781,6 сая төгрөг буюу нийтдээ 4 төсөл арга хэмжээний 3376,2 сая төгрөгийн санхүүжилтийг 2024 онд багтаан санхүүжүүлж чадахгүй нөхцөл байдал үүссэн. Үлдэгдэл санхүүжилтийг ЗГ-ын шийдвэр гарвал дундын данс буюу барьцаа хөрөнгийн дансанд байршуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үүнээс 2 ТАХ огт эхлээгүй, 2 төсөл арга хэмжээ гүйцэтгэлээр хянагдсан. ХО-ын ажлуудын зураг төсөл бэлэн болоогүй, магадлалаар баталгаажаагүй төсөл арга хэмжээг төсөвт тусгаснаас болж ХАА оройтож зарлагдаж, гэрээ байгуулагдсантай холбоотой. Он дамжин хэрэгжиж байгаа 5 ТАХ, санхүүжих дүн 7504,5 сая төгрөг, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 5908,5 сая төгрөгийн санхүүжилт олгож 3 төсөл арга хэмжээ нь ашиглалтанд орж улсын комисс ажилласан. Соёл амралтын хүрээлэнгийн багц 2 гэрээт ажил газар шорооны нэмэлт ажил болон ЦДАШ-ын нүүлгэн шилжүүлэлттэй холбоотойгоор удааширсан. Баяндэлгэр сумын 300 суудалтай Соёлын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцалсан тул уг ТАХ царцсан, хэрэгжээгүй.<br>Хүрсэн түвшин: 12 ТАХ 85% 5 ТАХ 80% | |
| 1.9.2 | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг зохион байгуулах | 23732,8 сая төгрөг | хэрэгжилтийн хувь | 54,5 | Эхний хагас жилд: 20 Жилийн эцэст: 75 | 2024 онд тоног төхөөрөмж худалдан авах 24 төсөл арга хэмжээний 5,807.3 сая төгрөг, тухайн онд санхүүжих дүн нь 2,556.1 төгрөг байна. 2024 онд шинээр 14 ТАХ-ний бараа, тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөн 13 ТАХ гэрээ байгуулан ажилласан. Нэг төсөл арга хэмжээний хувьд орлого төвлөрөлт бага байгаагаас шалтгаалан хэрэгжээгүй. Орон нутгийн хөгжлийн сан хариуцсан албан хаагч шинээр ажиллаж эхэлсэнтэй холбоотойгоор ОНХС-р хийгдэх бараа тоног төхөөрөмжийн 9 гэрээ тус албан хаагч руу шилжиж хийгдсэн. ОНХС санхүүжилтээр хийгдэх 9 төсөл хөтөлбөрийн худалдан авалт 100% хэрэгжсэн. Санхүүжилтийг бүрэн олгож ажилласан.Үүнд: 3-р сургуулийн хичээлийн тоног төхөөрөмж 150,0 сая төгрөг, Модны нүх ухах трактор 109,0 сая төгрөг, Онгон сумын дэд станц 150,0 сая төгрөг, Наран сумын усны машин 71,5 сая төгрөгөөр худалдан авч, гэрээг дүгнэн ашиглагч байгууллагуудад тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. 2024 онд 59 нэр төрлийн ажил төсөвт өртөг нь 41,506 сая төгрөг, тухайн онд санхүүжих дүн нь 18,436 сая төгрөг батлагдсан. Үүнээс шилжих 27 төсөл арга хэмжээ, санхүүжих дүн 7,692 сая төгрөг, шинээр хэрэгжүүлэх 32 төсөл арга хэмжээ санхүүжих дүн 10,744 сая төгрөг байна. Оны эцсийн байдлаар 36 төсөл арга хэмжээний 8,599.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Үүнээс дурдвал: Талын наран зохиолч яруу найрагчдын цэцэрлэгт хүрээлэн 1,440 сая төгрөг, Дулааны станцын засвар 1-р багц 1,614 сая төгрөг, Асгат сумын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулийн их засвар 473 сая төгрөг , Онгон сумын эрүүл мэндийн төв 423 сая төгрөг, Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ 697 сая төгрөг гэх мэт томоохон төсөл арга хэмжээг санхүүжилтийг олгосон. 2024 онд 50 нэр төрлийн зөвлөх үйлчилгээ төсөвт өртөг нь 4,531,3 сая төгрөг, тухайн онд санхүүжих дүн нь 2,697,0 сая төгрөг батлагдсан. Үүнээс шинээр 38 зөвлөх үйлчилгээний 1,869.2 сая төгрөгийн гэрээг байгуулан 24 төсөл арга хэмжээнд гүйцэтгэлээр 1,062.6 төгрөгийн санхүүжилт олгосон.<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 1.9.3 | Төсөл хөтөлбөрөөс санхүүжих хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг зохион байгуулах | 6259,3 сая төгрөг | хэрэгжилтийн хувь | 85 | Эхний хагас жилд: 50 Жилийн эцэст: 100 | АДАПТ төсөл 70%, ОНТ 30%-ийн санхүүжилтээр Дарьганга сумын Ганга нуурын татамд 30 га талбайд 24.000 мод тарьж татмын ойжуулалт, 5151 м хашаа хамгаалалт, 10 га талбайд ойн цэвэрлэгээ арчилгааны ажлыг Гранд форест ХХК 315.0 сая төгрөгөөр, - Түмэнцогт сумын Хэрлэн голын татмын дагуу 20 га талбайд 16.000 мод тарьж татмын ойжуулалт, 5679 м хашаа хамгаалалт, 15 га талбайд ойн цэвэрлэгээ арчилгааны ажлыг Алтан солин ХХК 322.0 сая төгрөгөөр, Тус ажлыг хүлээн авах комиссыг аймгийн Засаг даргын 2024 оны А/357 дугаар захирамжаар байгуулж, 2024 оны 06 сард хүлээж авсан. - Түмэнцогт суманд Хэрлэн голын татмын дагуу 92 га талбайд 73.600 мод, 1234 м хашаа хамгаалалтын ажлыг Гранд форест ХХК 1.0 тэрбум төгрөгөөр, - Дарьганга суманд 4га, Наран суманд 9га газарт Ойжуулалт хийх ажлын тендер зарлагдаж "Модны эмч" ХХК шалгарсан. БОУАӨЯам тус компанитай 2024 оны 9 сарын 25-нд хамтран ажиллах 143.4 сая төгрөг бүхий гэрээг байгуулсан ба ажлын гүйцэтгэл 60%-тай буюу 2 суманд модны хашаа хамгаалалтыг бүрэн хийсэн, Нийт 10400 мод | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тарихаас 3200 ш-ийг тарьсан, 7200 ш модны нүхийг ухсан, үлдсэн модыг 2025 оны хавар тарина, уг ажлыг хүлээн авах комиссыг аймгийн Засаг даргын 2024 оны А/65 дугаар захирамжаар байгуулсан. Одоогоор 2 сумын 4 байршилд 142га буюу 113.600 мод тарьж, хашаажуулсан ба ургалт 75%-тай байна. Мөн АДАПТ төсөлтэй хамтран Асгат сумын 1-р багийн /Өлзийт баг/ Хадат булгийн эх, Онгон сумын 2-р багийн /Шар бүрд баг/ Шар бүрдний булгийн эх, Эрдэнэцагаан сумын 3-р багийн /Бадрах баг/ Хүйтэн булгийн эх, Уулбаян сумын 3 багийн /Тэгш баг/ Богд-Уулын булгийн эх, Халзан сумын 4 багийн /Хатавч/ Самын булгийн эхийг хашиж хамгаалах ажлын тендерт Гранд Авгуш ХХК шалгарч тус компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. 5 удаа тендер зарлагдаж, гэрээг тус компанитай оройтож байгуулсантай холбоотойгоор булаг хаших ажлыг 2025 оны 04 сараас хийхээр гэрээ байгуулаад байна.<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 1.10. | Байгаль орчныг хамгаалах улс, орон нутгийн бодлого арга хэмжээний хэрэгжилтийг хангах | 45,2 | зохион байгуулсан арга хэмжээний тоо | 6 | 8 | Нийт 412,6 сая төгрөгний 15 ажил төлөвлөснөөс 184,0 сая төгрөгний 11 ажил, арга хэмжээг зохион байгуулсан байна. | 90% |
| 1.10.1 | Байгаль орчны бохирдол доройтлыг бууруулах ажлыг зохион байгуулах | - | зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2 | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: 4 | Аймгийн хэмжээнд ААНБ-ууд нийтийн эдэлбэр газарт цэвэрлэгээ хийж, айл өрхийг цэвэрлэгээнд уриалж нийтийн эзэмшлийн талбай болон хатуу хучилттай авто зам 53.4 км, явган хүний зам 52048 м2, талбайн хог цэвэрлэгээ тогтмол хийгдэж байна. Хотын өнгө үзэмжийг сайжруулах, иргэдийн эрүүл, цэвэр | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэмцгэр орчинд ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Баруун-Урт сумын Засаг даргын А/263 тоот захирамжаар “Маргаашийн хоггүй хуудсыг хамттай эргүүлцгээе" уриан дор намрын бүх нийтийн цэвэрлэгээг 2024 оны 09 сарын 21-23-ний өдрүүдэд, 1,3,4,5,7,9-р багийн нутаг дэвсгэрт зохион байгуулсан ба 21 ААНБ хамрагдан 176 тн хог хаягдлыг ачиж хогийн нэгдсэн цэгт зөөвөрлөлөө. -"Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах" төслийн хүрээнд дахивар хог хаягдлыг хүлээн авах бичил цехэд ашиглалтад орсон ба хуванцар, гялгар уутыг худалдан авч эдийн засгийн эргэлтэнд оруулж дахин бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Дахин цуглуулсан хог хагдал 2022 онд 1598.6 тн, 2023 онд 9665.5 тн, Дахин боловсруулсан хог хаягдал 2023 онд 2040 тн байна. 2023 онд Дахивар дахин боловсруулах үйлдвэр нийт 2377.1кг хуванцар сав,184.1кг лааз, Гялгар уут 1221кг -ыг худалдан авч нийт 1.156.515 төгрөгийн зардал гаргаж, Үүнээс 306кг буталж шон хийхэд 866кг гялгар уут ашиглан Том хашааны шон 25 ш, жижиг хашааны шон 52 ш нийт 77 шон үйлдвэрлэн 1540000 төгрөгийн борлуулалт хийгээд байна. -Хөрсний бохирдлыг бууруулах хүрээнд 2024 онд Айл өрх, ААНБ-ын оролцоотой 182 эко арин цэврийн байгууламжийг нэмэгдүүлсэн бөгөөд 3 суманд улсын төсвийн 2 тэрбум төгрөгөөр сургууль цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг эко болгосон. Айл өрх ААНБ өөрсдийн хөрөнгөөр 113.9 сая төгрөгөөр эко арин цэврийн байгууламжийг бий болгосон байна. Баруун-Урт суманд нүхэн жорлонгийн ариутгал халдваргүйжүүлэлтийг аймгийн ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх зардлаас 3 сая төгрөг батлуулж, тус сумын ЗДТГ-тай хамтран 842 өрхөд хийж гүйцэтгэсэн.<br>Хүрсэн түвшин: 4 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.11. | Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулна | 6,0 | Ажлын гүйцэтгэлийн хувиар | 80 | 90 | “International Travel Mart 2024” ОУ-ын аялал жуулчлалын үзэсгэлэнд 7-8 төрлийн 100 гаруй бүтээгдэхүүн, 600 гаруй тараах материалтай оролцлоо. | 100% |
| 1.11.1 | Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, иргэдийг дэмжиж ажиллах | - | Дэмжсэн аж ахуйн нэгжийн тоо | 7 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 10 | 2024 оны 10 дугаар сарын 25-аас 27-ний өдрүүдэд “International Travel Mart 2024” ОУ-ын аялал жуулчлалын үзэсгэлэнг “Үндэсний соёл, аялал жуулчлал, технологийн хөгжил” уриан дор 25 дахь жилдээ аялал жуулчлалын бизнес эрхлэгчид хоорондоо туршлага хуваалцах, туршлага судлах цаашдын чиг хандлагыг тодорхойлох онцлогтой зохион байгууллаа. Тус үзэсгэлэнд Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг хамтран бүсээрээ нэгдэж нэгдсэн талбайгаар хамтран оролцсон нь өмнөх жилийн үзэсгэлэнгээс онцлогтой байлаа. Үзэсгэлэнд АЗДТГ, Соёл урлаг, аялал жуулчлалын газар, залуучуудын газар, Баруун-Урт сумын Дарьганга цай брэнд, Халзан сумын Батжаргалын Таанын сорс, Дарьганга сумын Аюурзаны Шилийн богд цай, Мөнх сайн үүд ХХК хамтран 7-8 төрлийн 100 гаруй бүтээгдэхүүн, 600 гаруй тараах материалтай оролцож нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчиллаа.<br>Хүрсэн түвшин: 2 а/х 6 ААН | 100% |
| 1.12. | Ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар орон нутагт оруулах хувь нэмэр, үр өгөөжийг | 10,0 | Орон нутгийн төсөвт дэмжлэг үзүүлсэн аж ахуйн нэгжийн тоо | 15 | 18 | Аймгийн Засаг даргын 2024 оны А/307 дугаар захирамжаар энэ оны 05 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд "Хариуцлагатай уул уурхай, орон нутгийн хамтын ажиллагаа-2024" уул уурхайн салбарын жилийн зөвлөгөөн уулзалт, арга хэмжээг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/321 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг энэ онд 16 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулах ажлыг зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлнэ. | | | | | байгуулан ажиллалаа. 12 дугаар сарын 10-ны байдлаар 14 аж ахуй нэгжтэй гэрээ баталгаажуулаад байна. | |
| 1.12.1 | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай нутгийн захиргааны байгууллага орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах | - | Гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн тоо | 15 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 18 | 2024 оны 05 дугаар сарын 28,29,30-ний өдөр зохион байгуулагдсан "Хариуцлагатай уул уурхай, орон нутгийн хамтын ажиллагаа 2024" зөвлөгөөн уулзалтаар аймгийн Засаг даргын 2024 оны А/185 дугаар захирамжаар байгуулагдсан орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ дүгнэх ажлын хэсэг 12 аж ахуй нэгжийн гэрээг дүгнэх арга хэмжээг зохион байгуулсан, үүнээс "Дорнын чулуулаг", "Хунт өгөөж", "Бадмаараг хаш", "Эм эл цахиурт овоо", "Цэгээн үүдэн", "Каскейд майнинг", "Эрдэнийн босго", "Монголжүюаньли", "Кинзроүд", "Адаэ" ХХК-иуд гэрээ байгуулсан, "Нагааранз", "Премиум көүл", "Эрдэнийн олз", "Андын илч", "Эрээн толгой" ХХК-иудтай хэлцэл хийж, гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлэн ажилласан.<br>Хүрсэн түвшин: 12 | 90% |
| 1.12.2 | “ Хариуцлагатай уул уурхай ба орон нутгийн хамтын ажиллагаа 2024” салбарын жилийн уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах | 5,0 | Арга хэмжээнд оролцогчдын тоо | 60 | Эхний хагас жилд: 80 Жилийн эцэст: - | "Хариуцлагтай уул уурхай, орон нутгийн хамтын ажиллагаа-2024" уул уурхайн салбарын жилийн зөвлөгөөн уулзалт, арга хэмжээнд аймгийн удирдлага, уул уурхайн үйл ажиллагаа явагдах 7 сумын Засаг дарга, аймгийн холбогдох хэлтэс, агентлаг, нэгжийн удирдлага, мэргэжилтнүүд, 18 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжийн захирал, төлөөлөл зэрэг 80 орчим төлөөллийг хамруулан зохион байгуулсан.<br>Хүрсэн түвшин: 80 | 100% |
| 1.13. | Төрийн байгууллагын дотоод үйл | - | Систем ашиглалтын хувь | 30 | 50 | 2024 онд Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран нь 9 сумын 45 байгууллага болон аймгийн төвийн агентлаг, төсөвт байгууллагын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн ашиглалт хэрэглээг нэмэгдүүлэх | | | | | 400 гаруй албан хаагчдад танхимаар сургалтыг зохион байгууллаа.Цахим шилжилтгэй холбоотой агентлаг, төсөв байгууллага, сумдад тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, егр системийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх, албан бичиг солилцооны дундын системд холбох талаар албан бичгээр чиглэл хүргүүлж, сумдын Засаг дарга нар Аймгийн Засаг даргатай төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх гэрээнд систем ашиглалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг тусган өгч ажилласан. 2024 оны 12 дугаар сарын байдлаар зохион байгуулсан сургалтын тоо 3, зөвлөгөө мэдээллээр хангасан байгууллагын тоо 61, системд бүртгэгдсэн байгууллагын тоо 145 болж, ашиглалт 79 хувьтай хэрэгжиж байна. | |
| 1.13.1 | Дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд хэвлэмэл хуудсыг цахим хэлбэр шилжүүлэх | - | Хэвлэмэл хуудсыг цахимд шилжүүлсэн байгууллагын тоо | 0 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 40 | Аймгийн хэмжээнд 13 сум, агентлаг, төсөвт байгууллагуудад р 400 гаруй албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Нийт 79 байгууллага албан бичиг солилцооны дундын системд холбогдож бусад төрлийн системүүдээс цахимаар албан бичиг хүлээн авах боломжтой болсон.<br>Хүрсэн түвшин: 79 | 100% |
| 1.13.2 | Дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд бүртгэлтэй байгууллагууд ыг албан бичиг солилцооны дундын системд | - | Албан бичиг солилцооны дундын систем холбогдсон байгууллагын тоо | 52 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 35 | 2024 онд Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран нь 9 сумын 45 байгууллага, аймгийн төвийн агентлаг, төсөвт байгууллагын 400 гаруй албан хаагчдад албан бичиг солилцооны дундын системийн талаар танхимыг сургалт зохион байгууллаа. 2024 оны 12 дугаар сарын байдлаар зохион байгуулсан сургалтын тоо 3, зөвлөгөө мэдээллээр хангасан байгууллагын тоо 61, системд бүртгэгдсэн байгууллагын тоо 145 болж, ашиглалт 79 хувьтай хэрэгжиж байна.<br>Хүрсэн түвшин: 61 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холболт хийлгэх | | | | | | |
| 1.13.3 | Дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн ашиглалтын сургалтыг зохион байгуулах | - | Сургалтад хамрагдсан байгууллагын тоо | 8 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 50 | 2024 оны цахим шилжилтийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн систем ашиглалтыг нэмэгдүүлэх сумд, агентлаг, төсөвт байгууллагуудад зөвлөгөө мэдээлэл, сургалт өгөх зорилгоор Сүхбаатар аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэст системийн сургалтыг өгч ажиллалаа. Цахим шилжилттэй холбоотой агентлаг, төсөв байгууллага, сумдад тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, егр системийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх, албан бичиг солилцооны дундын системд холбох талаар албан бичгээр чиглэл хүргүүлж, сумдын Засаг дарга нар Аймгийн Засаг даргатай төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх гэрээнд систем ашиглалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг тусган өгч ажилласан. Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран нь 9 сумын 45 байгууллага болон аймгийн төвийн агентлаг, төсөвт байгууллагын 76 албан хаагчдад тус тус сургалтыг зохион байгууллаа.<br>Хүрсэн түвшин: 76 | 100% |
| 1.13.1 | Төрийн цахим үйлчилгээний “Хурдан” төвийг сумдад операторын горимоор хүргэхэд дэмжлэг үзүүлж ажиллах | 2,0 | Нэмэгдсэн хурдан цэгийн тоо | 3 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 7 | "Цахим Сүхбаатар" дэд хөтөлбөрт цэгүүдийн тоог нэмэгдүүлэх, 24/7 үйлчилгээний төвийг нэвтрүүлэх, төрийн үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлэх талаар арга хэмжээнүүдийг тусган өгч ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын байдлаар Төрийн үйлчилгээний хурдан төвийн үйл ажиллагааг сайжруулах, иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх чиглэлээр сумдын Засаг дарга нар Аймгийн засаг даргатай байгуулсан гэрээнд "Хурдан" цэгийг сумдад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр 1 арга хэмжээ тусган | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өгч, сүхбаатар аймаг дахь төрийн цахим үйлчилгээний хэлтсээр дамжуулан 12 суманд нэгдсэн хаягтай болгох, иргэдэд төрийн үйлчилгээний нэгдсэн системийн заавар, зөвлөгөө мэдээллээр хангах арга хэмжээг тус тус авч хэрэгжүүллээ. Баруун-Урт сумын Авто тээврийн төв дээр шинээр төрийн үйлчилгээний коиск машиныг Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс байршуулаад байна.<br>Хүрсэн түвшин: 5 | |
| 1.14. | “Тоон гарын үсгийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах | 1300,0 | Тоон гарын үсэгжүүлсэн иргэдийн тоо/хувь Зохион байгуулсан арга хэмжээ | 8887 4 | 11000 5 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай хууль, тэдгээртэй нийцүүлж гаргасан бусад хууль тогтоомж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, аймгийн 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсаны дагуу орон нутагт цахим засаглалын үйл ажиллагааны зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сум, агентлаг, төсөвт байгууллагад чиглэл хүргүүлж, уг чиглэлээр төрийн цахим үйлчилгээний хэлтсээр дамжуулан тоон гарын үсгийн хуулийн талаар сургалтыг 9 суманд танхимаар, төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд тоон гарын үсэг ашиглах талаар цахим хэлбэрээр 5 сум, 7 төрийн байгууллагад зөвлөгөө мэдээлэл өгөөд байна. "Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног" нэгдсэн арга хэмжээний хүрээнд Цахим засаглал, цахим шилжилтийн чиглэлээр төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийн чиглэлээр "Төрийн албан хаагчдад цахим ур чадвар, мэдлэг олгох" сургалтыг 2024 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 05 дугаар сарын 29-ний өдөр танхимын хэлбэрээр агентлаг, төсөв байгууллагын удирдлага, хүний нөөц, бичиг хэрэг, мэдээллийн технологи хариуцсан албан нийт 76 албан хаагчид хөтөлбөрийн дагуу тоон гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилт, ашиглалт хэрэглээний сургалтыг зохион байгууллаа.Байгууллагын удирдлага, албан хаагчдад тоон гарын үсэг ашиглан төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд ашиглах, албан бичигт тоон гарын үсэг зурах талаар биечлэн заавар зөвлөгөөг өгч, тоон гарын үсэгт ашиглагдах программ хангамжийг суулгасан | |
| 1.14.1 | Тоон гарын үсгийн олголтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, зохион байгуулах | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 4 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 5 | Орон нутагт цахим засаглалын үйл ажиллагааны зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сум, агентлаг, төсөвт байгууллагад чиглэл хүргүүлж, төрийн цахим үйлчилгээний хэлтсээр дамжуулан тоон гарын үсгийн хуулийн талаар сургалтыг 9 суманд танхимаар, төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд тоон гарын үсэг ашиглах талаар цахим хэлбэрээр 5 сум, 7 төрийн байгууллагад нийт 400 гаруй албан хаагчид зөвлөгөө мэдээлэл хүргэж ажиллалаа. "Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног" нэгдсэн арга хэмжээний хүрээнд Цахим засаглал, цахим шилжилтийн чиглэлээр төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийн чиглэлээр "Төрийн албан хаагчдад цахим ур чадвар, мэдлэг олгох" сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр танхимын хэлбэрээр агентлаг, төсөв байгууллагын удирдлага, хүний нөөц, бичиг хэрэг, мэдээллийн технологи хариуцсан албан нийт 125 албан хаагчид хөтөлбөрийн дагуу тоон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилт, ашиглалт хэрэглээний сургалтыг зохион байгууллаа.<br>Хүрсэн түвшин: 2 | |
| 1.14.2 | Албан хаагчдыг тоон гарын үсгээр хангах, ашиглалтыг нэмэгдүүлэх | 1,3 | Шинээр болон шинэчлэн олсон албан хаагчийн тоо Ашиглалтын хувь | 40 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 60 | Байгууллагын удирдлага, албан хаагчдад тоон гарын үсэг ашиглан төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд ашиглах, албан бичигт тоон гарын үсэг зурах талаар заавар зөвлөгөөг өгч, тоон гарын үсэгт ашиглагдах программ хангамжийг суулгасан . 2024 онд байгууллагын удирдах болон гүйцэтгэх 10 албан хаагчдад шинээр тоон гарын үсгийн гэрчилгээг авах ажлыг зохион байгууллаа.<br>Хүрсэн түвшин: 10 | 90% |
| 1.15. | Төрийн байгууллагын цахим хуудсаны хэвийн ажиллагааг хангах | 29,0 | Цахим хуудсаны архивлалт хийгдсэн тоо | 4 | 4 | Аймгийн цахим хуудсанд 2 удаа өгөгдлийн сангийн нөөцлөлт, аюулгүй байдлын үүднээс цахим хуудас ажиллуулахад шаардагдах нэмэлт 11 залгаасын шинэчлэлтийг хийж гүйцэтгэлээ. Нэмэлтээр цахим хуудсанд Site Quality Monitoring буюу сайтын хяналтын залгаасыг суулган ашиглаж байна. Аймгийн цахим хуудсанд байрлах хэлтсийн танилцуулгуудыг шинэчилж, хуудасны харагдах байдлыг 1 загварт оруулсан. | 90% |
| 1.15.1 | Цахим хуудсаны шинэчлэл хийх, шаардлагатай нэмэлтүүдийг худалдан авч байршуулах | 2,0 | Шинэчлэл хийгдсэн тоо | 1 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1 | 2024 оны 12 дугаар сарын байдлаар аймгийн цахим хуудсанд 3 удаа өгөгдлийн сангийн нөөцлөлт, аюулгүй байдлын үүднээс цахим хуудас ажиллуулахад шаардагдах нэмэлт 12 залгаасын шинэчлэлтийг хийж гүйцэтгэлээ. Нэмэлтээр цахим хуудсанд Site Quality Monitoring буюу сайтын хяналтын залгаасыг суулган ашиглаж байна. Аймгийн цахим хуудсанд байрлах хэлтэс нэгжийн танилцуулгуудыг шинэчилж, хуудасны харагдах байдлыг 1 загварт оруулсан. Цахим хуудас | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байршуулах 5GB дискний хэмжээг нэмэгдүүлэх хүсэлтийг Үндэсний дата төвд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 3 | |
| 1.16. | Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг дээдлэх хандлагыг төлөвшүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах | 30,0 | Зохион байгуулсан арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 91,6 | 92 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой нэмэлт өөрчлөлт, бусад хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр бага насны хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, тэдэнд "Замын хөдөлгөөний дүрэм"-ийн мэдлэг олгох зорилгоор хүүхэд багачууд, багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг, эхчүүдийн дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Замын хөдөлгөөний цагаан толгой-2024” тэмцээнийг амжилттай зохион байгуулсан.Иргэдийг согтууруулах ундаанаас татгалзуулах зорилгоор “Сэрэмж” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээ, 25 удаагийн нэгдсэн үзлэг, шалгалтыг санаачлан зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх яриа таниулга, уулзалтыг зохион байгуулан ажиллаж байна.Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулдаг “Мандах нар” “Зөв боломж” зэрэг АА-ийн ТББ-уудтай согтууруулах ундаанаас татгалзах, түүний хор уршгийн талаар уулзалтыг зохион байгуулж иргэдийг хамруулсан байна.Цас зудад нэрвэгдэж, уруудсан малынхаа араас явж, сургийг гаргаж чадахгүй байгаа малчид, иргэдэд туслах зорилгоор 900 бичлэгээр 15,000 орчим бод малыг баримтжуулан “Эгэл малчны эрхэм хүсэл” нэртэй фейсбүүк групп цахим орчинд түгээснээр тоогоор 29,000 иргэн хандаж, 1200 иргэн сэтгэгдэл бичиж, 1120 орчим иргэн талархсан сэтгэгдэл бичиж, бичлэг зургаас 100 орчим иргэд малаа харсан талаараа мэдэгдээд байна.Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, хохирогч иргэнд төрийн үйлчилгээг үзүүлэх, айл өрхөд нууц далд үйлдэгдэж буй гэр бүлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүчирхийлэл үйлдэгдэж байгаа эсэхийг тодруулах зорилгоор “Тандалт судалгааны хуудас” бөглөж хэвшсэн байна. “Гэр бүлийн үнэ цэнэ" уулзалт зохион байгуулж, сургалтад 52 иргэн хамрагдаж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 төрлийн 20 ш самбар хийж гэр бүлийн хүчирхийлэл голчлон үйлдэгддэг, иргэд ихээр цуглардаг олон нийтийн газруудад байршуулан нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулан ажилласан. Хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлт, хүний эрхийн хэрэгжилт зэрэг сэдвүүдээр 31 удаагийн танхимын сургалт зохион байгуулж, 516 хүн хамрагдсан . | |
| 1.16.1 | Эрх зүйн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | - | Хамрагдсан иргэд, албан хаагчид Зохион байгуулсан сургалт, сурталчилгааны ажлын тоо | 250 27 | Эхний хагас жилд: - - Жилийн эцэст: 550 30 | Аймгийн нэгдсэн эмнэлэг, Зэвсэгт хүчний 168 дугаар тусгай салбар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Татварын хэлтэс, Цаг уур орчны шинжилгээний газар, Санхүүгийн хяналт аудитын алба, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газар, Байгаль орчны газар, Авто тээврийн үндэсний төвийн Сүхбаатар салбар, Аймгийн Засаг даргынн тамгын газар зэрэг байгууллагууд, аймгийн төвийн агентлаг, байгууллагын удирдах ажилтнууд, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар, орон нутгийн залуучуудад Гэрээ байгуулахад анхаарах асуудал, Шийдвэрийн төсөл боловсруулахад анхаарах асуудал, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнд хүлээлгэх хариуцлага, ХАСХОМ гаргахад анхаарах асуудал, Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг, түүнд хүлээлгэх хариуцлага, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжид орсон өөрчлөлт, хуулийн зохицуулалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Үндсэн хууль, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, хүний эрхийн хэрэгжилт зэрэг сэдвүүдээр 31 удаагийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танхимын сургалт зохион байгуулж, 516 хүн хамрагдсан байна.<br>Хүрсэн түвшин: 31 516 | |
| 1.16.2 | Хууль зүйн туслалцааны төвийн салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангаж, иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэхэд хамтарч ажиллах | - | Авсан арга хэмжээний тоо Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авахаар хандсан иргэдэд үйлчилгээ үзүүлсэн хувь | 2 100 | Эхний хагас жилд: - - Жилийн эцэст: 2 100 | Энэ онд бүртгэлээр 59 хүнд хууль зүйн зөвлөгөө, мэдээллийг биечлэн болон утсаар өгч ажилласан бөгөөд үүнээс 10 хүнд шүүхэд гаргах нэхэмжлэл, хариу тайлбар, төрийн байгууллагад гаргах гомдол бичиж өгсөн байна. Мэдээлэл, зөвлөгөө авсан хүмүүсээс 32 хүн нь төрийн албан хаагч нар, бусад 17 нь иргэд эзэлж байна. Мэдээлэл, зөвлөгөөг агуулгаар нь авч үзвэл Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, цалин, түүний нэмэгдэл, Ашиг сонирхлын зөрчил, мэдэгдэл, тайлбар гаргах, Захиргааны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, иргэний эрх зүйн бусад гэрээ хэлцлийн талаар голчлон хандсан байна.<br>Хүрсэн түвшин: 100 | 100% |
| 1.16.3 | Гэр бүлийн хүчирхийлэл, мал хулгайлах, архидан согтуурахтай тэмцэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ зохион байгуулах | 5,0 | Ажлын гүйцэтгэлийн хувь | 100 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100 | Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дэргэдэх түр хамгаалах байранд үйлчлүүлсэн хохирогч иргэд тэдний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалж нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж байрлуулсан ба тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй” аяны хүрээнд аймгийн МСҮТ, ЕБС-ийн ахлах 10-12 дугаар ангийн сурагчдад “Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэл”, “Архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээ, хор уршиг” сэдвээр сургалт зохион байгуулж, сургалтад 1650 хүүхэд хамрагдсан. Ахуйн хүрээнд болон гудамж талбайд байнга архидан согтуурдаг, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, үйлдэж болзошгүй, архины хамраалтай 72 иргэнийг “Зөв боломж” АА бүлгэмтэй хамтран ажилласан. Мөн цагдаагийн алба хаагчид өдөр, оройн цагаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаандаа ахуйн хүрээнд архидан согтуурах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, ухуулга, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, байнгын хяналт тавин ажиллаж байна. Иргэдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчилд өртөх, хохирох эрсдэлийг бууруулах, соён гэгээрүүлэх, эрх зүйн мэдлэг олгох зорилгоор холбогдох хуулиудын нэмэлт өөрчлөлт, бусад хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр 24 удаагийн сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, сургалтад ААН, байгууллагын 980 иргэн хамрагдсан. Аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, илрүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Бод”, “Малын хулгай” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлье”, “Шугаман эргүүл”, “Хамгаалах бүс”, “Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал”, “Замын хөдөлгөөний цагаан толгой- 2024”, “Хүүхдийг эрсдэлээс сэргийлье” зэрэг нэгдсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэртээ үр дүнтэй зохион байгуулсан.<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 1.16.4 | Төрийн архивт хадгалагдаж байгаа сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж стандартын шаардлага хангасан | 10,0 | Тоног төхөөрөмжөөр хангагдсан хувь | 75 | Эхний хагас жилд: 90<br>Жилийн эцэст: - | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, “Баримт бичгийн хэвлэмэл хуудас тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавих шаардлага” MNS 5140-3:2021 стандарт болон аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд Хэвлэгч машин авч албан хэрэгцээнд ашиглах асуудлыг аймгийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэн, 8 дугаар сараас ашиглаж эхлээд байна. Уг тоног | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тавиур, шүүгээ, тоног төхөөрөмжөөр хангах | | | | | төхөөрөмжийг ашиглалтад оруулснаар хэвлэмэл хуудастай холбоотой стандартыг аймгийн хэмжээнд мөрдүүлэх, төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтөд нийтлэг гарч буй хэвлэмэл хуудас, бүрдэлтэй холбоотой зөрчлийг арилгах боломж бүрдэж байгаа төдийгүй 98 албан байгууллагаас захиалга авч 55420 ш хэвлэмэл хуудас хэвлэн, байгууллагын нэмэлт орлогын дансанд 9,642,200 төгрөгийн орлого оруулаад байна. Түүнчлэн документ сканер цахим дэлгүүрээс худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Ингэснээр цахимын ажилтнуудын хүлээгдэл чирэгдэл багасч, ажлын ачаалал хөнгөрсөн. Мөн ХШТасгаас баримт ариутгагч тоног төхөөрөмжийг шинээр данс бүртгэлээр хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.<br>Хүрсэн түвшин: 100<br>Хавсралт: 1 файл | |
| 1.16.5 | Төрийн архивт хадгалагдаж байгаа баримтуудыг цахимд шилжүүлэх ажлыг зохион байгуулах | - | Цахимд шилжүүлсэн баримтын эзлэх хувь | 19 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 25 | Төрийн архивт хадгалагдаж байгаа захирамжлалын баримт бичгийн 90 гаруй хувийг цахим хэлбэрт шилжүүлэн цахим мэдээллийн сан үүсгэж эх баримтыг ашиглалтаас чөлөөлж байгууллага, иргэдэд захирамжлалын баримт бичигтэй холбогдолтой лавлагаа, мэдээллийг тухай бүр нь олгож чирэгдэлгүй үйлчилж байна. Энэ онд Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар, Боловсролын газар, Үйлдвэрчний эвлэлийн 3 байгууллагын 214 хадгаламжийн нэгжийн 12735 хуудас баримтыг скайнердаж, photoshop-оор засварласан, програмд оруулж, цахим холболт хийсэн.<br>Хүрсэн түвшин: 8 хөмрөг 11 данс 733 хадгаламжийн нэгж 39202 хуудас | 100% |
| 1.16. | Архив албан | 5 | Орон тоо | 4 | Эхний | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 20.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах | | | | хагас жилд: 5 Жилийн эцэст: - | болон АЕГ-аас ирүүлсэн чиглэл зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд тасгийн алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг дараах байдлаар хийж ажиллалаа. Архивын тасгийн зааварлагч-арга зүйч байгууллага дотроо шилжин ажиллах болсон тул түүний оронд сан хөмрөгчийн албан тушаалд ажиллаж байсан албан хаагчийг, мөн сан хөмрөгч өөр ажил руу шилжсэнтэй холбоотой гэрээт архивч-оператороор ажиллаж байсан албан хаагчийг сан хөмрөгчөөр томилон үндсэн албан хаагч болгоод байна. Түүнчлэн албан хаагчдын ажлын ачааллыг жигдрүүлэх үүднээс тасгийн үндсэн албан хаагчдын "Албан тушаалын тодорхойлолт"-ыг шинэчлэн боловсруулж, аймгийн Төрийн албаны салбар зөвлөл болон байгууллагын хүний нөөц, удирдах албан тушаалтанд хүргүүлж ажиллалаа.<br>Хүрсэн түвшин: 5 | |
| 1.17. | Иргэн цэргийн харилцааг бэхжүүлэн, Улсын батлан хамгаалах эрх ашигт нийцсэн орон нутгийн хамгаалалт, дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болгоно. | 26,0 | Ажлын гүйцэтгэлийн хувиар | 80 | 100 | Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон үндсэн чиглэлд Батлан хамгаалах бодлого, Батлан хамгаалах салбарын багц хууль,Зэвсэгт хүчний тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр тусгагдсан ажлуудыг төлөвлөгөө гарган хийж хэрэгжүүлэн ажиллаж байна | 100% |
| 1.17.1 | Ерөнхий боловсролын сургуульд цэрэг дайчдын ''Алдарын | 6,0 | шинээр байгуулсан тахимын тоо | 4 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 6 | Аймгийн засаг дарга, сумдын засаг дарга нартай байгуулах гэрээнд тусган хэрэгжилтийг хanган хяналт тавин ажиллаж байна6<br>Хүрсэн түвшин: - | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | танхим’’ байгуулах | | | | | | |
| 1.17.2 | Хээрийн дадлага сургалтын нэгдсэн төвийг байгуулах | - | ажлын гүйцэтгэлийн хувиар | 85 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 100 | Аймгийн иргэдийн нийтийн хурлаар Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн сургалтын төвийг шинээр барих 80 сая төгрөг шийдүүлж 75 хувийн гүйцэтгэлтэй байсан бөгөөд нэмэлтээр шаардагдах 20 сая төгрөгийг 2024 оны төсөвт суулган шийдүүлж сургалтын төв ашиглалтад ороод байна.<br>Хүрсэн түвшин: 100 | 100% |
| 1.17.3 | Орон нутгийн хамгаалалтын техник хэрэгсэл, бараа материалын нөөцийг үе шаттай бүрдүүлэх | 20,0 | Бараа материал бүрдүүлсэн эсэх | 1 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 1 | Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт оруулан нийт 30 сая төгрөгөөр нөөц бүрдүүлээд байна. Аймгийн Засаг дарга сумдын засаг дарга нартай 2024 онд хамтран ажиллах гэрээнд Орон нутгийн хамгаалалтын нөөцийг сум тус бүрд бүрдүүлэхээр гэрээ байгуулан ажилласан.<br>Хүрсэн түвшин: 100 | 100% |
| 1.18. | Албан хаагчийн ур чадварыг 5 хувиар нэмэгдүүлэх | 650,0 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээний дундаж хувиар | 92 | 97 | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд хүний нөөцийн нөхөн хангалтыг хийх, төрийн албан хаагчдийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор жил бүр тодорхой төсөв батлуулж, тухайн жилд дэмжлэг олгох салбар болон холбогдох журам, удирдамжийг боловсруулан баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Эрүүл мэнд, боловсрол, соёл спортын салбарын албан хаагчдад орон сууцны дэмжлэг олгох удирдамжийн боловсруулан төлөвлөсөн ч сонгуулийн жил, төсвийн орлого зэргээс хамааран олгоогүй. Эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа журмын болзол хангасан оюутнуудтай гэрээ байгуулж нийт 7 оюутанд 24 сая төгрөгийн тэтгэлэгийг олгов. “Хүний нөөцийн Нийгмийн баталгаа хангах” хөтөлбөрийн хүрээнд орон нутагтаа байгаа багш нарын нөөц | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бололцоог ашиглаж, ажлын туршлага, ур чадвартай багш нараа дайчилж баг болгон зөвлөх багшаар 2 багшийг ажиллуулж, математик физикийн давтлагад ахлах ангийн 100 гаруй сурагчдыг хамруулав. Тус үйл ажиллагаанд 70 гаруй сая төгрөг зарцуулсан | |
| 1.16.1 | Аймгийн хэмжээний төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх | - | Зарцуулсан хөрөнгө Хэрэгжилтийн хувь | 450,0 40 | Эхний хагас жилд: - - Жилийн эцэст: 650,0 50 | Байгууллагын нэгдсэн зөвлөгөөнийг 1-р сард зохион байгуулж, хөдөлмөрийн дотоод журамд санал авсан ба албан хаагчдаас нийт 7 нэмэлтээр оруулах санал ирж 6 саналыг нь дэмжин, хамт олны 100 хувийн саналаар баталсан. Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд Тусгай үүргийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд соёл, дэг журмын хэрэгжилтийг хангах арга хэмжээг тусгуулан ажилласан. "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 6 дугаар зүйлд заасан тусламж дэмжлэгийн болзол шаардлага хангасан албан хаагчдын өргөдөл, хүсэлтийг хүлээн авч 100 хувь шийдвэрлэсэн. Үүнд: орон сууцны дэмжлэг 6 хүнд тус бүр 2 сая төгрөг, хагалгаанд орсон 3 хүнд тус бүр 1 сая төгрөг, шинэ хүүхэдтэй болсон 3 хүнд тус бүр 500,000 төгрөг, ар гэр нь хагалгаанд орсон 2 хүнд тус бүр 500,000 төгрөг, бусад ар гэрийн гачигдал тохиолдсон 5 хүнд нийт 2,9 сая төгрөг, хүүхэд асрах чөлөөтэй байгаа 2 хүнд сар бүр 100,000 төгрөг, өөрөө болон үр хүүхэд нь хурим хийсэн 2 хүнд тус бүр 1 сая төгрөг, өөр ажилд шилжсэн 2 хүнд тус бүр 1 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмж, энгийн галлагаатай сууц, гэрт амьдардаг 3 хүнд тус бүр 300,000 төгрөгийн мөнгөн тусламжийг олгоод байна. Мөн 50 насны ой тохиож буй 1 хүнд 500,000 төгрөг, салбарын "Тэргүүний ажилтан" тэмдэгээр шагнуулсан 2 хүнд тус бүр 300,000 төгрөг, ажил мэргэжлийн чиглэлээр уралдаан тэмцээнд орж тэргүүлсэн 8 хүнд тус бүр 400,000 төгрөгийн урамшууллыг олгоод байна. Албан хаагчдын нийгмийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баталгааг хангах болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд албан хаагчдын дунд зохион байгуулсан спортын тэмцээнд нийт 2 сая төгрөг, албан хаагчдын хүүхдүүдэд зориулсан арга хэмжээнд 7,1 сая төгрөгийг тус тус зарцуулаад байна.<br>Хүрсэн түвшин: 100 | |
| 1.16.2 | Албан хаагчдын сургалтын хэрэгцээнд суурилсан сургалт, дотоод, гадаадад туршлага судлах, томилолтоор ажиллуулах зэргээр албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүй, ур чадварыг сайжруулах | - | Багц сургалтад хамрагдсан албан хаагчдын эзлэх хувь | - | Эхний хагас жилд: -<br>Жилийн эцэст: 1 | 2024 оны сургалтын төлөвлөгөөнд тусгах саналыг авч, нэгтгэн, 38 арга хэмжээ төлөвлөснөөс тус байгууллагын албан хаагчдад зориулсан 28 сургалт, арга хэмжээг 20 сая төгрөгөөр төсөвлөн, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 4 албан хаагч хамрагдаж байгаагаас төрийн албанд анх томилогдсон иргэнийг чиглүүлэх сургалтад 2, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1, дунд хугацааны давтан мэргэшүүлэх багц сургалтад 1, ахлах түшмэлийн багц сургалтад 2 албан хаагч манай байгууллагаас хамрагдаж байгаа бол аймгийн хэмжээнд нийт 41 албан хаагч 4 чиглэлийн сургалтад хамрагдаж байна. Төлөвлөгөөнд туссаны дагуу албан хаагчдыг сэтгэл зүйн бүлгээр болон ганцаарчилсан зөвлөгөөнд хамруулж байна. Мөн мэргэжлийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад 13 албан хаагчийг хамруулж 2,2 сая төгрөг, бусад сургалтад холбогдох зардлыг зарцуулсан.<br>Хүрсэн түвшин: 1 | 100% |
| 1.19. | Төрийн албаны хууль тогтоомж, албан хаагчийн | 20,000,000 | Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийн | 80 | 90 | Удирдах ажилтны зөвлөгөөнд аймгийн 40 байгууллагын удирдлагуудад төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт анхаарах асуудлын талаар мэдээлэл хийсэн. 7 хоног | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ёс зүй, хариуцлагыг дээшлүүлнэ. | | хувь | | | бүрийн удирдах ажилтын шуурхай мэдээллийн цагт аймгийн нийт удирдах албан хаагчдад төрийн албаны хууль тогтоомж,, Төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгдөг. Мөн утсаар, цахимаар, биечлэн Төрийн албны хууль тогтоомжийн хэрэгжил, хэрэгжүүлэх арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг тасралтгүй хийж хэвшээд байна. | |
| 1.19.1 | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | - | Арга зүйн дэмжлэг үзүүлсэн байгууллагын тоо | 13 | Эхний хагас жилд: - Жилийн эцэст: 31 | Салбар зөвлөл 2024 онд 20 удаа хуралдаж, салбар зөвлөлийн үндсэн зорилтыг тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, төлөвлөгөөнд тусгасны дагуу аймаг орон нутгийн хэмжээнд Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актыг хэрэгжилтэй танилцаж, зөвлөн туслах үйл ажиллагааны удирдамж батлах, ерөнхий болон тусгай шалгалтын ажлын хэсэг, комисс байгуулах, шалгалтын бэлтгэл ажлыг хангах, тусгай шалгалтад бүртгүүлэгчдийн материалыг хянаж, бүртгэх эсэх тухай шийдвэр гаргах, шалгалтад тэнцсэн иргэдийн шалгалтын дүнг хүлээн зөвшөөрөх, санал болгож, нэр дэвшүүлэх, зэрэг дэв олгох, иргэний иргүүлсэн гомдлыг хэлэлцэх зэрэг асуудлаар хуралдаж, нийт 68 тогтоол гаргаж, холбогдох асуудлыг шийдвэрлэсэн байна. Хуралдаан тус бүрийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдааны албан тэмдэглэлээр албажуулсан болно.<br>Хүрсэн түвшин: 31 | 100% |
| 1.20. | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын бодлогыг хот төлөвлөлтэй | 400,0 | Арга хэмжээний тоо | - | 3 | Аймгийн орон нутаг хөгжлийн сангийн 600,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Наран суманд төрийн албан хаагчдад зориулсан 4 айлын орон сууц барих зураг төслийн ажлыг хийж гүйцэтгэж байна. Мөн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 3 дугаар багийн нутаг дэвсгэрт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | уялдуулж иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх | | | | | шинээр соёмбо хорооллын 75 айлын орон сууц, Шинэ тэмүүлэл хотхоны 35 айлын орон сууц, Хос өргөө апармент хотхоны 85 айлын орон сууц, Баян шарга хотхоны 35 айлууд тус онд улсын комиссын шийдвэрээр ашиглалтад орсон байна. | |
| 1.20.1 | Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх | - | Ашиглалтад орсон орон сууцны өрхийн тоо | 35 | Эхний хагас жилд: 35 Жилийн эцэст: 250 | 960 айл орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ажлын зургийг хийж гүйцэтгэн улсын төсвийн 3,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дэд бүтцийн шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэж байна. Тус төсөл арга хэмжээний төсөв 2024 онд улсын төсөвт батлагдаагүй бөгөөд Сүхбаатар аймагт болсон эдийн засаг хөгжлийн форум, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас зохион байгуулсан орон нутагт орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх форумуудад оролцсон хөрөнгө оруулагч бизнесийн төлөөлөлд тус ажлын хөрөнгийг шийдвэрлэх талаар танилцуулсан. 2025 оны төсөвт үлдсэн хөрөнгийг тусгах саналыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд хүргүүлсэн.<br>Хүрсэн түвшин: - | 100% |
| 1.20.2 | Сумдын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан, үе шаттайгаар хэрэгжүүлэх | 400,0 | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн сумдын тоо Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн тоо | 6 2 | Эхний хагас жилд: 6 2 Жилийн эцэст: 10 3 | Асгат, Түвшинширээ, Наран, Дарьганга сумдын төлөвлөгөөг шинээр дахин хийх тендерийг 2 багц болгон зарлаж Асгат, Түвшинширээ сумдын ЕТ-г Артконстракш ХХК, Наран, Дарьганга сумдын ЕТ-г Ди ди эй Жи ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна. Эдгээр 4 сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийж гүйцэтгэх ажлын хүрээнд ерөнхий төлөвлөгөө хийх суурин судалгааны ажил болон дэвсгэр зургийн тодруулга, инженер геологийн дүгнэлт хийх ажлуудыг хийж гүйцэтгүүлсэн.<br>Хүрсэн түвшин: 4 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.20.3 | Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж, хянаж, тайлагнах. | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | Эхний хагас жилд: 30 Жилийн эцэст: 90 | 2024 оны байдлаар одоо эзэмшиж байгаа газраа өмчлөх хүсэлт гаргасан 686, шинээр газар өмчилж авах хүсэлт гаргасан 11993 иргэн, аж ахуйн зориулалтаар газар өмчилж авахыг хүссэн 29 иргэд нийт 12708 иргэн газар өмчилж авах хүсэлт гаргасан байна. Өнөөдрийн байдлаар Засаг даргын захирамжаар газар өмчлүүлэхээр шийдвэрлэсэн иргэдийн тоо 11838, шинээр өмчлүүлсэн газрын нийт хэмжээ 1124,40 га бөгөөд гэр бүлийн зориулалтаар 1121,39 га, аж ахуйн зориулалтаар 2,66 га газар өмчлүүлсэн байна.<br>Хүрсэн түвшин: 93,1 | 100% |
